

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## АГУУЛГА

### УДИРТГАЛ

#### НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

- 1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь
- 1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох
- 1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
- 1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох
- 1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох
- 1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

#### ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

#### ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Шалгуур үзүүлэлт 1. Геодези, зураг зүйн тухай хуулийн зохицуулалтууд мөн хуулийн зорилтыг хангаж чадаж байгаа эсэх, хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтод хүрсэн эсэх?

3.2. Шалгуур үзүүлэлт 2. Геодезийн сүлжээ байгуулах зохицуулалтууд практикт нийцэж байгаа эсэх?

3.3. Шалгуур үзүүлэлт 3. Геодезийн цэг тэмдэгттэй холбоотой хуулийн зохицуулалт практикт хэрэгжиж байгаа эсэх?

3.4. Шалгуур үзүүлэлт 4. Геодезийн багаж баталгаажуулалттай холбоотой зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?

3.5. Шалгуур үзүүлэлт 5. Газар зүйн нэртэй холбоотой зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?

3.6. Шалгуур үзүүлэлт 6. Газрын зураг, түүний хэрэглээтэй холбоотой зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?

3.7. Шалгуур үзүүлэлт 7. Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сангийн зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?

3.8. Шалгуур үзүүлэлт 8. Улсын хилийн шугам болон засаг захиргааны хилийн эргэлтийн цэг, бүх төрлийн кадастрын зураглалын эргэлтийн цэгийг тогтоох зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?

3.9. Шалгуур үзүүлэлт 9. Геодезийн хэмжилт, зураглалын ажилд хяналт тавих зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?

3.10. Шалгуур үзүүлэлт 10. Хуулиар зохицуулагдаагүй харилцаа байгаа эсэх?

#### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

## УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлаас Геодези, зураг зүйн тухай хуулийг 1997 оны 10 дугаар сарын 31-ний өдөр 3 бүлэг, 15 зүйл, 44 хэсэг, 83 заалттайгаар баталсан бөгөөд геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулах зорилготой байдаг.

Геодези, зураг зүйн тухай хууль анх батлагдсанаас хойш бусад холбогдох хууль шинээр болон шинэчлэн боловсруулагдсантай холбоотой нийт 16 удаа нэмэлт, өөрчлөлт орсноос 14 зүйлийн 3 хэсэг, 13 заалтыг хүчингүй болгож, 23 хэсэг, 12 заалтад нэмэлт, өөрчлөлт орж, 2 хэсэг, 5 заалт шинээр нэмэгдсэн байгаа нь Хуулийн нийт хэсгийн 64 хувь, заалтын 36 хувьд өөрчлөлт оржээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-аар Геодези, зураг зүйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлээ.

Үнэлгээ хийх ажил нь хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийх, хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, тодорхой шалгуур үзүүлэлтэд үндэслэн дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх зорилготой.

Геодези, зураг зүйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь Аргачлалын 2.1-д заасны дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн.

## НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

### 1.1.Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон тухайн хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлов.

Монгол Улсын Их Хурлаас Геодези, зураг зүйн тухай хуулийг 1997 оны 10 дугаар сарын 31-ний өдөр 3 бүлэг, 15 зүйл, 44 хэсэг, 83 заалттайгаар баталсанаас хойш өнгөрсөн 27 жилийн хугацаанд нийт 16 удаа /1999, 2000, 2001, 2003 онд 3 удаа, 2005, 2011, 2015, 2016, 2017, 2022 онд 3 удаа, 2023, 2024 онд/ нэмэлт, өөрчлөлт орсноос 14 зүйлийн 3 хэсэг, 13 заалтыг хүчингүй болгож, 23 хэсэг, 12 заалтад нэмэлт, өөрчлөлт орж, 2 хэсэг, 5 заалт шинээр нэмэгдсэн байгаа нь Хуулийн нийт хэсгийн 64 хувь, заалтын 36 хувьд өөрчлөлт оржээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт 3.6.Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана гэсэн зорилт тавьж, “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 3.6.1-т “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж заасан ба газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоход Газрын тухай, Геодези, зураг зүйн тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай гэх мэт холбогдох хуулиудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлага бий болсон.

“Хууль тогтоомжийн тухай” хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэж заасан байдаг ч Геодези, зураг зүйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт тусгайлан үнэлгээ хийгдээгүй байна.

Мөн түүнчлэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл энэ хуулийн тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр заасан.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн дээрх заалтуудыг үндэслэн Геодези, зураг зүйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээг хийсэн болно.

## 1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаагаар нь тухайн хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлдог.

Хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх болсон шалтгаантай харилцан уялдаа, хамааралтайгаар тогтоох ба тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг сонгоно. Ингэхдээ хуулийг бүхэлд нь эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.

Энэхүү үнэлгээгээр Геодези, зураг зүйн тухай хуулиар зохицуулсан үндсэн харилцаа, зохицуулалтуудыг агуулгын хувьд бүхэлд нь үнэлэхийг хичээж үнэлгээ хийх хүрээг тус хуулийн дараах зүйл заалтуудаар тогтоов. Үүнд:

Хүснэгт 1

№	Үнэлэгдэх	
	зүйл	хэсэг, заалт
1	<b>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</b>	1.1.Энэ хуулийн зорилт нь геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.
2	<b>4 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагаа</b>	4.1.Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд дараахь ажил хамаарна: 4.1.1.геодезийн сүлжээ байгуулах, одон орны тодорхойлолт, гравиметрийн хэмжилт хийх, төрөл бүрийн масштабын байр зүйн болон мөрөн, гол, нуурын ёроолын зураг үйлдэх, шинэчлэх, хэвлэх; 4.1.2.агаар, сансраас газрын зураг авах, боловсруулалт хийх; 4.1.3.төрөл бүрийн масштабтай тусгай зориулалт бүхий сэдэвчилсэн, сургалтын болон нийтийн хэрэгцээний газрын зураг зохиох, шинэчлэн хэвлэх; 4.1.4.хот, тосгон, бусад суурины газар доорх болон дээрх инженерийн байгууламж, ерөнхий төлөвлөгөө, тохижилтын дэвсгэр зураг хийх, шинэчлэх; 4.1.5.газар зүйн нэрийн жагсаалт (каталог) зохиож хөтлөх, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх; 4.1.6.дэлхийн хэлбэр, хэмжээ, газрын гадаргын хэвтээ, босоо хөдөлгөөнийг тодорхойлох, зайнаас тандан судлах зэрэг геодези, зураг зүйн эрдэм шинжилгээний судалгаа явуулах; 4.1.7.геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан бүрдүүлэх; 4.1.8.улсын хилийн шугамын байршлыг геодезийн аргаар тодорхойлох, шалгах;

		4.1.9.газар, хот байгуулалт, инженерийн шугаман байгууламж, геологи, уул уурхайн болон бусад бүх төрлийн кадастрын зураг үйлдэх, инженер хайгуул, барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалтын үеийн геодезийн хэмжилт явуулах, өрөмдлөгийн цооног холбох;
		4.1.10. улсын аюулгүй байдлыг хангах болон гамшиг болон аюул үүсэх нөхцөлд геодези, зураг зүйн ажил гүйцэтгэх.
3	<b>8 дугаар зүйл.Геодези, зураг зүйн улсын хяналт</b>	8.1.Геодези, зураг зүйн улсын хяналт нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэний геодези, зураг зүйн талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, дүрмийн биелэлтийг хангана.
		8.2.Геодези, зураг зүйн улсын хяналтыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.
		8.3.Геодези, зураг зүйн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.
4	<b>9 дүгээр зүйл.Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан</b>	9.1.Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан /цаашид "нэгдсэн сан" гэх/ нь геодезийн сүлжээний, байр зүйн зургийн, агаар, сансрын зургийн, газар зүйн нэрийн болон кадастрын тухай мэдээлэл, тэдгээртэй холбогдох бусад тоон мэдээллээс бүрдэнэ. Нэгдсэн сан нь төрийн өмч байна.
		9.2.Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь улсын болон орон нутгийн төсөв, төрийн байгууллага хэрэгжүүлж буй төслийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлынхаа тайлан, эх материал, солбицлын жагсаалт (каталог), бүдүүвч зураг, бичлэг, бусад тоон мэдээллийг нэгдсэн санд үнэ төлбөргүй шилжүүлнэ.
		9.3.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хөрөнгөөр гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын тайлан, бусад материалыг худалдан авч болно.
		9.4.Нэгдсэн сан дараахь зүйлээс бүрдэнэ: 9.4.1.геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад байгаа газрын зураг, хэвлэлийн эх, гэрэл зургийн хальс, тайлан, солбицолын жагсаалт (каталог), бусад тоон мэдээлэл; 9.4.2.энэ хуулийн 9.2-т заасны дагуу байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс ирүүлсэн материал; 9.4.3.бусдад худалдах, олшруулах эрхгүйгээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс худалдан авсан, энэ хуулийн 9.4.1, 9.4.2-т зааснаас бусад онц чухал материал; 9.4.4.байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс өөрсдийн үйл ажиллагаа, бүтээлийг сурталчлах зорилгоор нэгдсэн санд ирүүлж байгаа зураг, тоон мэдээлэл, тоног төхөөрөмжийн тухай танилцуулга.
5	<b>10 дугаар зүйл.Геодезийн байнгын цэг, тэмдэгт</b>	10.1.Геодезийн байнгын цэг, тэмдэгт нь төрийн өмч байна.
		10.2.Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлуулсан бол уг цэг, тэмдэгтийн байрлаж байгаа сум, дүүргийн Засаг даргад, хилийн зурваст бол хил хамгаалах

		<p>ерөнхий газрын харьяа тусгай ангийн удирдлагад хүлээлгэж өгнө.</p> <p>10.3.Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна. Уг цэг, тэмдэгтийг хөдөлгөх, нүүлгэн шилжүүлэх зайлшгүй шаардлага гарвал түүнийг сэргээн босгох зардлыг хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.</p> <p>10.4.Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг арчлан хамгаалахад дараахь журмыг баримтална:  10.4.1.тухайн цэг, тэмдэгт байрлаж байгаа газар, барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь түүнийг хамгаалах, геодезийн үйл ажиллагааг саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ;  10.4.2.нутаг дэвсгэртээ байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцна;  10.4.3.хилийн зурваст байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдалд хил хамгаалах ерөнхий газар, тухайн цэг, тэмдэгт байрлаж байгаа нутаг дэвсгэр дэх хилийн отряд хяналт тавина;  10.4.4.геодезийн байнгын цэг, тэмдэгтийг гэмтээсэн, устгасан, хэмжилт хийх нөхцөлийг алдагдуулсан тохиолдолд Засаг дарга, хил хамгаалах ерөнхий газар нь геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна.</p>
6	<b>11 дүгээр зүйл.Газар зүйн нэр</b>	<p>11.1.Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг газар зүйн албан ёсны нэрийн тухай мэдээллээр хангах, газар зүйн нэрийг зөв бичих, хэрэглэх, хамгаалах асуудлыг сум, дүүргийн Засаг дарга, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн хамтран зохицуулна.</p> <p>11.2.Газар зүйн нэрийн жагсаалт зохиох, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх, нэрийг зөв бичих, шинээр өгсөн нэр болон нэрийн өөрчлөлтийн бүртгэл хөтлөх, газрын зурагт тусгах зэрэг ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь шинжлэх ухааны болон холбогдох бусад байгууллагын санал авч хэрэгжүүлнэ.</p> <p>11.3.Газар зүйн нэрэнд дараахь объектын нэр хамаарна:  11.3.1.эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр, тал, говь, цөл, мөрөн, гол, нуур зэрэг физик газар зүйн объект;  11.3.2.хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, усан сан, суваг, шуудуу;  11.3.3.улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээрийн доторх хөдөө аж ахуй, үйлдвэр, тээвэр, холбоо зэрэг бусад объект.</p> <p>11.4.Газар зүйн хуучин нэрийг тодотгох, шинээр тогтоохдоо лавлагааны болон түүхийн эх сурвалжид үндэслэх бөгөөд аливаа эх сурвалж байхгүй бол нутгийн уугуул иргэд, мэргэжлийн хүмүүс, судлаачдын саналыг үндэслэн тогтооно.</p>

		<p>11.5.Шинээр байгуулсан объектыг нэрлэхэд дараахь зарчим баримтална:  11.5.1.тухайн объектыг нээх, судлах, барьж байгуулахад оролцсон буюу эзэмшиж байгаа хүний нэрээр нэрлэх;  11.5.2.газар зүйн хуучин нэрээр нь зүг чиг, өнгө, цаг хугацааны тодотголтой нэрлэж болох;  11.5.3.ойролцоо орших өөр төрлийн объектууд нь ижил нэртэй байж болох.</p> <p>11.6.Газар зүйн нэрийг дараахь онцгой тохиолдолд өөрчилж болно:  11.6.1.адил төрлийн хэд хэдэн объектын ижил нэр нь зам, тээвэр, харилцаа холбоо, бусад байгууллагын ажилд хүндрэл учруулахаар байвал;  11.6.2.уугуул иргэд нь нэрлэж заншсан уламжлалт нэрийг сэргээх хүсэлт тавьсан;  11.6.3.тухайн объектын мөн чанарт тохирохгүй, этгээд хэллэгээр нэрлэгдсэн байвал.</p> <p>11.7.Шинээр нэрлэх, өөрчлөх газар зүйн нэр дараахь шаардлагыг хангасан байна:  11.7.1.хүрээлэн буй орчин, газар зүйн объектын тодорхой шинж, түүх, соёл, ахуйн онцлогийг тусгасан байх;  11.7.2.монгол хэлний бичлэг, хэллэгт тохиромжтой гурваас илүүгүй үгээс бүтсэн байх.</p> <p>11.8.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах газар зүйн нэрийг Засгийн газар нэгтгэн Улсын Их Хурлаар батлуулна.</p>
--	--	---

### 1.3.Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан. Үнэлгээ хийх асуудал тодорхой болсон үед тодорхой 1 шалгуур үзүүлэлтийг сонгон авах бөгөөд зөвхөн 1 шалгуур үзүүлэлтээр тухайн асуудалд бүрэн үнэлэлт өгөх боломжгүй тохиолдолд 2 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлтийг сонгох боломжтой.

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Геодези, зураг зүйн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

**1.Зорилгод хүрсэн түвшин.** Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоодог. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд зохимжтой гэж үзэж сонгосон болно. Өөрөөр хэлбэл, энэ шалгуур үзүүлэлтээр Хаягжуулалтын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд анх батлах үед төлөвлөж байсан зорилгод хүрсэн эсэхийг тогтоох боломжтой.

Энэхүү шалгуур үзүүлэлтээр Геодези, зураг зүйн тухай хууль нь хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд анх батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг тогтооно.

Үндсэн зорилгыг тус хуулийн нэгдүгээр зүйлд Геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино хэмээн заасныг баримтлан геодези, зураг зүйн салбарын үйл ажиллагааг бүхэлд нь хамруулж байгаа эсэх, салбарын хяналт нэн тэргүүний чухал асуудал хэмээн тодорхойллоо.

**2.Практикт нийцэж байгаа байдал.** Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Геодези, зураг зүйн тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Хүснэгт 2

№	Үнэлэгдэх		Шалгуур үзүүлэлт
	зүйл	хэсэг, заалт	
1	1 дүгээр зүйл	1.1 дэх хэсэг	Зорилгод хүрсэн түвшин
2	4 дүгээр зүйл	4.1 дэх хэсэг	Практикт нийцэж байгаа байдал
3	8, 9, 10, 11 дүгээр зүйл	бүхэлдээ	Практикт нийцэж байгаа байдал

#### 1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох

Аргачлалын 3.5.1-д заасны дагуу хууль хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг.

Геодези, зураг зүйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхэд түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамаарч хамаарч Аргачлалын 3.5.3-т заасан:

1. байх ёстой ба одоо байгаа;
2. хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш;
3. хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
4. тохиолдол судлах гэсэн 4 харьцуулах хэлбэрээс “байх ёстой ба одоо байгаа”, “тохиолдол судлах” гэсэн харьцуулах хэлбэрүүдийг сонгосон болно.

**“Байх ёстой ба одоо байгаа”** харьцуулах хэлбэрийн хүрээнд Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн 1997 оноос хойш бий болсон үр дагавар /одоо байгаа нөхцөл байдал/-ыг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, үндэсний хэмжээний хөтөлбөрийн зорилго, олон улсын байгууллагын зүгээс тогтоосон шаардлага болоод олон улсад сайн жишиг тогтоосон гадаад улсын туршлага зэрэгтэй харьцуулах хэлбэрээр тус хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохыг зорив.

**“Тохиолдол судлах”** харьцуулах хэлбэрээр Геодези, зураг зүйн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт нь өөр өөр нөхцөл буюу тохиолдолд хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Мөн бусад улсын хууль тогтоомжийг харьцуулж судлах нь Геодези, зураг зүйн тухай хуулийг боловсронгуй болгох ажлын хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай гэж үзэв. Гэхдээ манай улсын тэргүүлэх эрдэмтэн судлаачдын судалгааны үр дүнд тодорхой болсон асуудлын хувьд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын “Хэрэв шалгуур үзүүлэлтийг томъёолох явцад асуудал тодорхой болсон тохиолдолд цаашид түүгээр мэдээлэл цуглуулах шаардлагагүй. Харин үнэлгээндээ асуудал тодорхой болсныг үндэслэлтэй тайлбарлана.” гэсэн арга зүйг баримталсан.

Хүснэгт 3

Төлөвлөх үе шат			
№	Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэрийг сонгох
1	1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг	Зорилгод хүрсэн түвшин ямар байна вэ	Байх ёстой ба одоо байгаа
2	4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг	Практикт нийцэж байгаа байдал	Байх ёстой ба одоо байгаа

3	8-11 дүгээр зүйл	Практикт нийцэж байгаа байдал	Тохиолдол судлах
---	------------------	-------------------------------	------------------

### 1.5.Шалгуур үзүүлэлтийг томъёолох

“Шалгуур үзүүлэлтийг томъёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “**зорилгод хүрсэн түвшин ямар байна вэ?**”, “**практикт хэрхэн нийцэж байна вэ?**” гэх асуултын хүрээнд гүйцэтгэлээ.

### 1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү үнэлгээний ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор архив, мэдээллийн сан, мэргэжилтнүүдийн өгсөн тоон үзүүлэлтүүд, баримт бичиг, эрдэм шинжилгээ, судалгааны эх сурвалжууд уншиж судлах, харьцуулалт хийх аргаар хэрэгцээтэй мэдээлэл олж авсан. Мэдээлэл цуглуулах дараах аргыг ашигласан болно. Үүнд:

Аргачлалын 3.7.3.1-д заасны дагуу “Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах” хүрээнд: Монгол Улсын Үндсэн хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон дээр дурдсан баримт бичиг, норм ба дүрэм, ном, гарын авлага, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, өгүүлэл, статистикийн тоо баримт цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.

Мөн Геодези, зураг зүйн тухай хуулийг бусад улсын харьцуулсан судалгааг хийж, үндэслэл болгов.

## ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд мэдээлэл цуглуулах аргыг ашиглан судалгааны хэрэгжүүлэх үе шатны холбогдох ажиллагаануудыг хийж гүйцэтгэлээ. Геодези, зураг зүйн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай болон байгаа мэдээллийг цуглуулах аргаар дараах холбогдох материалыг цуглуулан дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

### 1.Монгол Улсын хууль:

- 1/Монгол Улсын Үндсэн хууль;
- 2/Геодези, зураг зүйн тухай хууль /1997он/;
- 3/Авто замын тухай хууль /2017 он/;
- 4/Зөрчлийн тухай хууль /2017 он/;
- 5/Барилгын тухай хууль /2016 он/;
- 6/Ашигт малтмалын тухай хууль /2006 он/;
- 7/Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995 он/;

### 2.Бусад улсын хууль:

- 1/ОХУ-ын Геодези, зураг зүй болон орон зайн өгөгдлийн тухай хууль;
- 2/БНХАУ-ын Хэмжил зураглалын тухай хууль;
- 3/Япон улсын Хэмжлийн тухай хууль;

### 3.Бусад:

- 1/Барилгын геодезийн ажил БНБД11-08-06;
- 2/Барилга байгууламжийн инженер геодезийн ажил БД81-103-06;
- 3/1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил БД11-106-08;

4/Агаарын зураглалын ажлын заавар БД11-113-12;  
5/Авто зам болон төмөр замын геодезийн ажил БД 11-114-14;  
6/Монгол Улсын өндрийн I ба II ангийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм БНБД 11-09-16;

7/Өндрийн I, II ангийн сүлжээний тэгшитгэн бодолтын ажил БНБД 11-107-16;

8/Кадастрын зураглалын ажил БНБД 11-11-16;  
9/Ус, дулаан хангамж, ариутгах татуургын сүлжээ, үерийн усны байгууламжийн геодезийн ажил БД 11-115-16;

10/Монгол улсын Гравиметрийн тулгуур сүлжээ байгуулах үндсэн дүрэм БНБД 11-10-17;

11/Өндөр барилга байгууламжийн хэв гажилтыг тодорхойлох, үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмж суурилуулах, үеийн геодезийн хэмжилт БД 11-118-17;

12/Эрчим хүч, харилцаа холбооны инженерийн байгууламжийн геодезийн ажил БД 11-120-17;

13/Өндрийн III ба IV ангийн сүлжээ байгуулах БД 11-121-19;

14/Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл БНБД 11-07-19;

15/Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил БД 11-104-19;

16/Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил БД 11-105-19;

17/Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ БД 81-103-21;

18/Нисгэгчгүй нисэх төхөөрөмж, агаарын зураглал ба газрын зураг гүйцэтгэх ажил БД 11-124-21;

19/Геодези, зураг зүйн үйлдвэрлэлд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм БНБД 11-12-22;

20/"1:10000, 1:25000, 1:50000, 1:100000-ны масштабтай байр зүйн зураглалын ажил БД 11-124-21;

21/Навигацийн хиймэл дагуул (GNSS)-ийн технологиор Монгол Улсын геодезийн сүлжээ байгуулах дүрэм БНБД 11-13-226;

22/Ном, сурах, бичиг, эмхэтгэл:

- Хэрэглээний геодези Б.Дэмбэрэл;
- Геодезийн нэр томъёоны тайлбар толь А.Дамдинсүрэн 2013 он;
- Геодези, тэргүүн дэвтэр А.Дамдинсүрэн, Ж.Алтанцэцэг, Б.Рагчаа 2017 он;

## **ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ**

Энэ үе шатанд төлөвлөх үе шатанд сонгож авсан үнэлгээний хүрээ буюу Геодези, зураг зүйн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт тус бүрийг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлсэн болно.

Мөн Хэрэгжилтийн үе шатанд цуглуулж, уншиж судалсан эх сурвалжид тусгагдсан мэдээлэлд үндэслэж, Геодези, зураг зүйн тухай хуулийн боловсронгуй болгох шаардлагатай, зарим зүйл, заалт, хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг хөндлөө.

Монгол Улсын Их Хурлаас Геодези, зураг зүйн тухай хуулийг 1997 оны 10 дугаар сарын 31-ний өдөр 3 бүлэг, 15 зүйл, 44 хэсэг, 83 заалттайгаар баталсанаас хойш өнгөрсөн 27 жилийн хугацаанд нийт 16 удаа /1999, 2000, 2001, 2003 онд 3 удаа, 2005, 2011, 2015,

2016, 2017, 2022 онд 3 удаа, 2023, 2024 онд/ нэмэлт, өөрчлөлт орсноос 14 зүйлийн 3 хэсэг, 13 заалтыг хүчингүй болгож, 23 хэсэг, 12 заалтад нэмэлт, өөрчлөлт орж, 2 хэсэг, 5 заалт шинээр нэмэгдсэн байгаа нь Хуулийн нийт хэсгийн 64 хувь, заалтын 36 хувьд өөрчлөлт оржээ.

### **3.1.Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.Геодези, зураг зүйн тухай хуулийн зохицуулалтууд мөн хуулийн зорилтыг хангаж байгаа эсэх, хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтод хүрсэн эсэх?**

Геодези, зураг зүйн тухай хуулиас үнэлгээ хийхээр сонгож авсан эхний хуулийн заалт бол “Хуулийн зорилт” гэсэн 1 дүгээр зүйл байгаа.

Геодези, зураг зүйн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан.

Геодези, зураг зүйн тухай хууль 1997 онд батлагдсанаас хойш өнөөг хүртэл хугацаанд 46 хувь нь өөрчлөгдсөн байна. Энэхүү 46 хувийн өөрчлөлт нь салбарын суурь асуудлыг хөндөөгүй зөвхөн Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдож болон бусад салбарын хуулиудад өөрчлөлт орсон, шинэчлэгдэн батлагдснаас хамаарч төрийн байгууллагуудын эрх, үүрэгтэй холбоотой хийгдсэн байна.

Хууль 28 жил хэрэгжсэн, энэхүү жилүүдэд дэлхий даяар Геодези, зураг зүйн салбарт техник, технологийн үсрэнгүй хөгжил эрчимтэй явагдсан байгаа нь Шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийн эрин үед геодезийн хэмжилт, зураглалын шинэ арга, хэрэгсэл, тоног төхөөрөмж үйлдвэрлэлд нэвтэрч, өргөнөөр ашиглагдаж байгаатай холбоотойгоор үйл ажиллагааны нэр, төрөл, тоо нэмэгдсэн, шинэ нэр томъёо бий болсон, хуульд геодези, зураг зүйн үйл ажиллагааг бүрэн тодорхойлоогүй үлдээсэн, геодези, зураг зүйн үйл ажиллагаа захиалагч, хэрэглэгч төрийн байгууллагуудын чиг үүрэг гүйцэд тодорхойлогдоогүйгээс салбар бүрт хийж байгаа геодези, зураг зүйн ажлын үр дүн геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн санд төвлөрдөггүй, 1:100000-аас том масштабтай байр зүйн зургууд төрийн нууцад хамаардгаас эдгээр зургийг энгийн хэрэглээнд ашиглахад хүндрэлтэй байдаг, геодези, зураг зүйн үйл ажиллагаанд магадлал, магадлан хэмжилт, захиалагчийн техникийн хяналт хийх зохицуулалт тодорхойлогдоогүй, хэмжилтийн багаж ашиглаж хээрийн хэмжилт хийдэг “геодезийн хэмжилт, зураглалын” болон зөвхөн компьютер, програм ашиглан суурин боловсруулалт хийдэг “зураг зүйн” гэсэн хоёр өөр төрлийн үйл ажиллагаанд нэг ижил шалгуур тавьж “геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх” гэсэн нэг тусгай зөвшөөрөл олгодог байдлыг оновчтой болгох, төрийн бус байгууллагын талаарх зохицуулалт байхгүй байна.

Энэхүү 28 жилийн хугацаанд өндөр технологи, техникт суурилсан салбарын үйл ажиллагаа, нийгмийн харилцаанууд шинээр бий болжээ.

1.Геодези, зураг зүйн хэмжилт боловсруулалтын үйл ажиллагаанууд гараар зурдаг, боддог байсан үе халагдаж цахим буюу тоон систем нэвтэрсэн байна.

2.Багажнууд механик, аналог байсан бол автомат, дижитал болж хөгжсөн байна.

3.Бодолтуудыг гараар олон удаагийн үйлдлээр хийдэг байсан бол компьютерээр, программын тусламжтайгаар хийж байна.

4.GPS (Global Positioning System) хиймэл дагуулаас мэдээ хүлээн авч боловсруулалт хийн байрлал болон өндрийг тогтоох систем эрчимтэй хөгжиж үйлдвэрлэлд орж ирсэн. GNSS-ийн байнгын ажиллагаатай станцаар хамгийн өндөр нарийвчлалтайгаар сүлжээг хэмжиж, олон улсын станцуудтай холбогдон ажиллаж Монгол орны тектоник хөдөлгөөн болон хавтангын хөдөлгөөнийг судалж байна.

5.Төрөл бүрийн хиймэл дагуулаас дэлхийг судлах системүүд. Гравиметрийн хиймэл дагуул, сансрын зураг авах хиймэл дагуул, далай судлалын хиймэл дагуул, хиймэл

дагуулаас долгион илгээж түүнийгээ хүлээн авч 3 хэмжээст цэгэн үүл, загвар гаргах, мониторингийн буюу ажиглалтын хиймэл дагуулууд салбартай холбоотойгоор хөгжсөн байна.

6.Төрөл бүрийн дрон, нисгэгчгүй нисэх төхөөрөмжүүд үйлдвэрлэлд орж ирж байна.

7.Лазер сканнерууд, гэрлэн болон дууны долгионоор зайг хэмжих төхөөрөмжүүд, далай тэнгис, нуурын ёроолын зураг хийдэг багажнууд үйлдвэрлэлд нэвтэрч байна.

8.Нийгмийн харилцаанд шинээр жолоочгүй машин, нисгэгчгүй онгоц, уул уурхайн техникүүд хүртэл операторгүй ажиллаж байгаа нь газрын зурагт суурилсан бүтээгдэхүүн юм.

9.Ухаалаг хот (Smart City), 3D загварчлал (Digital Twin), үндэсний гео орон зайн өгөгдлийн дэд бүтэц (NSDI – National Spatial Data Infrastructure) зэргийн суурийг бэлддэг салбарт хуулийн шинэчлэл зайлшгүй шаардлагатай байна.

10.Томоохон мега төслүүд болох Хорин минутын хот, LRT, BRT, метро, туннел, Хархорум хот, хурдны зам, автозам, төмөр зам, уул уурхай, нисэх буудал, Хөдөө аж ахуй, Байгаль орчин, эрчим хүчний төслүүдэд эхнээс нь дуустал геодезийн хэмжилт зураглал, газрын зураггүйгээр төсөөлөшгүй билээ.

11.Газрын зураг масштабас хамааран нууцын зэрэгт байдаг бөгөөд хэрэглэгч хэрэглэж чадахааргүй байдалтай байдаг. Үүнийг нууцын жагсаалтад оруулсан элементээр зааглаж тусгай зориулалтын, нийцийн хэрэгцээний гэж зааглах зайлшгүй бодит шаардлага байна.

#### **Үнэлгээ:**

Геодези, зураг зүйн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.” гэж тодорхойлсон ч шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийн эрин үед геодезийн хэмжилт, зураглалын шинэ арга, хэрэгсэл, тоног төхөөрөмж үйлдвэрлэлд нэвтэрч, өргөнөөр ашиглагдаж байгаатай холбоотойгоор үйл ажиллагааны нэр, төрөл, тоо нэмэгдсэн, шинэ нэр томъёо бий болсон, хуульд геодези, зураг зүйн үйл ажиллагааг бүрэн тодорхойлоогүй үлдээсэн, геодези, зураг зүйн үйл ажиллагаа захиалагч, хэрэглэгч төрийн байгууллагуудын чиг үүрэг гүйцэд тодорхойлогдоогүй, GNSS-ийн байнгын ажиллагаатай станц, байнгын цэг тэмдэгт түүний хамгаалалтын бүс, мэдээллийн санд төвлөрүүлэх зохицуулалтыг орхигдуулсан нь зорилттойгоо нийцэхгүй байна.

Салбарын үйл ажиллагаанд шинэ оролцогч болох Төрийн бус байгууллагын оролцоог хуульчлах, төрөөс төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, төр аж ахуйн үйл ажиллагааг явуулахгүй байх зарчмыг дэмжих шаардлагатай байна.

Газрын зураг масштабас хамааран нууцын зэрэгт байдаг бөгөөд хэрэглэгч хэрэглэж чадахааргүй байдалтай байдаг. Үүнийг нууцын жагсаалтад оруулсан элементээр зааглаж тусгай зориулалтын, нийцийн хэрэгцээний гэж зааглах зайлшгүй бодит шаардлага байна.

Хүчин төгөлдөр мөрдөж байгаа геодези, зураг зүйн тухай хуульд 9 ширхэг нэр томъёог тодорхойлсон боловч зарим нэр томъёо тухайлбал:”геодези” гэдэг шинжлэх ухааны нэршлийг илэрхийлэх үндсэн нэр томъёог үйл ажиллагаа гэж буруу томъёолсон байхад олон тооны нэрийг тодорхойлоогүй орхигдуулсан байдаг. Нэр томъёоны тодорхойлолтыг өөрчилж найруулахаас гадна шинээр 20 гаруй нэр томъёог тусгах шаардлагатай байна.

Хүчин төгөлдөр мөрдөж байгаа геодези, зураг зүйн тухай хуульд 10 үйл ажиллагааг тодорхойлсон байдаг. Зарим үйл ажиллагааг төрийн байгууллага эсвэл хувийн ААН

хариуцан гүйцэтгэхийг тодорхой тусгаагүй. Шинжлэх ухаан технологийн дэвшилтэй холбоотой уг салбарт хэмжилтийн шинэ багаж, тоног төхөөрөмж, зураглалын арга технологи нэвтэрч буй тул шинэ зохицуулалтууд оруулах шаардлагатай байна. Тухайлбал: Хиймэл дагуулын технологид суурилсан геодезийн сүлжээ байгуулах шинэ арга технологи буюу Байнгын ажиллагаатай суурин станц байгуулж ажиллуулах зохицуулалт, агаарын зураглалын нисгэгчгүй нисэх төхөөрөмж/дроне/ ашиглан тоон байдлаар гүйцэтгэдэг болсон мөн сансрын зургийг тоон хэлбэрээр хүлээн авч агаарын сансрын тоон зургийг боловсруулантоон ортофото зураг, өндрийн тоон загвар зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болсон, геодезийн хэмжилт зураглалын ажилд GNSS буюу хиймэл дагуулын хэмжилтийн технологи, түүнд шаардлагатай геоидын өндрийн загвар ашигладаг болсон зэрэг технологийн шинэчлэлүүд үйлдвэрлэлд нэвтэрсэн тул хуульд эдгээрийн зохицуулалтуудыг оруулах шаардлагатай болсон.

Геодезийн өгөгдөл, мэдээлэл тоон болж, тэдгээрийг хадгалах, хамгаалах, шинэчлэх, үйлчилгээ үзүүлэхэд цахим технологи буюу мэдээлийн сан/систем ашиглах шаардлагат гарч улмаар эдгээртэй холбоотой зохицуулалтуудыг хуульд тусгах нэмэлт шаардлага бий болсон.

Эдгээрийг хуульд тусгаж оруулахад геодези, зураг зүйн үйл ажиллагааны тоо 30 гаруй болж нэмэгдэхээр байна.

### **3.2.Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2.Геодезийн сүлжээ байгуулах зохицуулалтууд практикт нийцэж байгаа эсэх?**

Солбицол, өндрийн тогтолцоог хамрах хүрээнээс нь хамааруулан **дэлхий нийтийн, улсын, орон нутгийн** гэж ангилдаг. Улс орон бүр өөрийн нутаг дэвсгэрт тохирсон солбицлын тогтолцоог зохион хэрэглэдэг ба түүний дүрэм, өгөгдлийг хууль, стандартаар баталгаажуулан геодезийн хэмжилт, зураглал үйлдэхэд мөрддөг.

Геодези, зураг зүйн тухай хуульд солбицол, өндөр, тусгаг, масштаб, дүрслэх хавтгайн тогтолцоог Монгол Улсын Засгийн газар батлахаар тусгасан бөгөөд одоо Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолоор баталсан солбицол, өндрийн тогтолцоог хэрэглэж байна.

Солбицол, өндрийн тогтолцоог хэрэглэх гол зорилго нь Монгол улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэж байгаа аливаа геодезийн хэмжилт, зураглалыг нэгдсэн нэг системд хийх, бүх төрлийн бүтээн байгуулалтыг алдаагүй, үнэн зөв, нарийвчлалтай гүйцэтгэх нөхцлийг хангах юм.

Улс орон хот, суурин зэрэг бага хэмжээний талбайг хамарсан талбайд барилга, байгууламж барих, инженерийн бүтээн байгуулалтад зориулж (дэлхийн гадаргуугийн муруйлтыг тооцдоггүй буюу гажилтгүй систем) орон нутгийн буюу солбицлын дэд тогтолцоог зохион хэрэглэдэг.

Манай улсад 2000 оноос өмнө хот суурин газар тус бүр өөрийн бие даасан солбицлын дэд тогтолцоог геодезийн хэмжилт, зураглалд хэрэглэж байсан боловч 2000 оноос хойш шинэ технологи тус салбарт нэвтэрсэнтэй уялдаж, суурин газрын геодезийн хэмжилт, зураглалд улсын солбицлын тогтолцоог ашиглах болсон.

Харин геодезийн сүлжээ нь улс орны нутаг дэвсгэрийг төрөл бүрийн масштабтай байр зүйн зургаар хангах, улсын болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийг тодотгон тогтоох, хот төлөвлөлт, уул уурхай, геологи хайгуул, авто зам, төмөр зам, дэд бүтэц, инженерийн төрөл бүрийн байгууламжийг төлөвлөх, барьж байгуулах, хянах зэрэг бүх үйл ажиллагааны тулгуур нь болдог онцгой ач холбогдолтой юм.

Геодезийн сүлжээг байгуулах арга, техник, ашиглах багажаас мөн дэлхийн хэлбэр, хэмжээ, татах хүчнээс хамааруулан **байрлалын, өндрийн, гравиметрийн** гэж ангилдаг.

Эдгээр сүлжээг байгуулах арга, хэмжих хэрэгсэл өөр өөр байдаг тул тус тусад нь байгуулж ирсэн түүхтэй.

Геодезийн сүлжээ гэсэн ойлголтод уламжлалт сүлжээ болох байрлал, өндөр, гравиметрийн сүлжээ багтдаг бөгөөд орчин үед навигацийн хиймэл дагуулын технологид суурилсан GNSS-ын 3 хэмжээст сүлжээг нэмж хамааруулдаг болсон.

Дээрх геодезийн 3 үндсэн сүлжээг байгуулах үйл ажиллагаа 1997 онд Геодези, зураг зүйн тухай хуулийг батлахаас өмнө хийгдсэн байна.

GPS/GNSS-ын 3 хэмжээст сүлжээг газар дээр болон агаарын орон зай дахь объектын 3 хэмжээст байрлал /x, y, z солбицол/-ыг дэлхийн массын төвтэй харьцангуйгаар, өндөр нарийвчлалтай тодорхойлоход ашигладаг.

Монгол улсад GPS-ийн технологи нэвтэрсэн 1997 оноос хойш өнөөдрийг хүртэл GNSS-ын сүлжээний олон ажлууд хийгджээ. Тухайлбал:

1. Монмет ХХК, ГХГЗЗГ-ын хамтран байгуулсан 30 цэгтэй сүлжээ /1997/
2. Монмэп ХХК-ийн байгуулсан 34 цэгтэй сүлжээ /1997-1998/
3. Монгол улс-БНХАУ-ын хилийн шугамын дагууд байгуулсан 60 цэгтэй сүлжээ /2002/
4. Монгол-ОХУ-ын хил шалгалтын ажилд зориулсан 8 цэгтэй сүлжээ /2002/
5. Монгол орны газар тариалангийн, хангайн, баруун, говийн болон зүүн бүсийн сүлжээ /2003-2006/
6. Монгол орны өндрийн сүлжээний зангилаа цэгүүдийн сүлжээ /2010/
7. Шинээр баригдах төмөр замын дагууд хийсэн сүлжээ /2011/
8. Гравиметрийн сүлжээний цэгүүдийн сүлжээ /2013/
9. Монгол-ОХУ-ын хил шалгалтын ажилд зориулсан 178 цэгтэй сүлжээ /2023/ зэрэг болно.

Мөн Геодези, зураг зүйн тухай хуульд геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах солбицол, өндөр, тусгаг, масштаб, дүрслэх хавтгайн тогтолцоог боловсруулах, батлах, мөрдөх талаар тусгасан байдаг ч солбицлын дэд тогтолцооны талаар ямар нэг зохицуулалт тусгагдаагүй байна.

Улсын солбицлын тогтолцооны талаарх судалгааг 6-р хүснэгтэд, солбицлын дэд тогтолцооны талаарх судалгааг 7-р хүснэгтэд тус тус үзүүлэв.

### **Улсын солбицлын тогтолцооны нөхцөл байдлын судалгаа**

*Хүснэгт 6*

д/д	Хуулийн хэрэгжилтийн судалгаа	Тийм/ үгүй	Тайлбар /зүйл, заалтын дугаар, хэрэгцээ, шаардлагыг энд бичих/
1	Геодези, зураг зүйн тухай хуулиар зохицуулсан зүйл, заалт, хэсэг		
1.1	Нэр томъёоны тодорхойлолт хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /3 дугаар зүйл/	үгүй	“Улсын солбицлын тогтолцоо” гэсэн нэр томъёог тодорхойлох шаардлагатай.
1.2	Геодези, зураг зүйн үйл ажиллагаа хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /4 дүгээр зүйл/	үгүй	Солбицлын тогтолцоо нь Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геодезийн хэмжилт, зураглалын ажил гүйцэтгэх үндэс тул хуульд түүнийг тодорхойлох, үйл ажиллагааг зааж оруулах шаардлагатай.
1.3	Төрийн байгууллагын чиг үүрэгт тусгагдсан эсэх /5 дугаар зүйл/	тийм	5.2.1, 5.5.1,

1.4	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний чиг үүрэгт тусгагдсан эсэх /6 дугаар зүйл/	тийм	6.1.3
1.5	Санхүүжилтийн асуудал тусгагдсан эсэх /7 дугаар зүйл/	үгүй	Геодезийн солбицлын тогтолцоо нь дэлхийн эргэх хөдөлгөөн, гадаад, дотоод таталцах хүчний нөлөөллөөс хамаарч цаг хугацааны явцад өөрчлөгдөж байдаг. Энэ өөрчлөлтийн нөлөөг тодорхой хугацаанд тооцож засварлаж байх зайлшгүй шаардлагатай бөгөөд үүнд гарах зардлыг зөвхөн улсын төсвөөс санхүүжүүлнэ. Иймээс санхүүжилтийн асуудлыг хуульд тусгах шаардлагатай.
1.6	ГЗЗ-н мэдээллийн улсын нэгдсэн санд хэрхэн шилжүүлэх, хадгалах, түгээх талаар тусгагдсан эсэх	үгүй	
1.7	Энэ асуудлаар хуулийн тусгайлсан зохицуулалт байгаа эсэх	үгүй	
1.8	Хориглосон зохицуулалт хуулинд байгаа эсэх /12 дугаар зүйл/	үгүй	Монгол Улсын нутаг дэвгэрт гүйцэтгэж байгаа геодези, зураг зүйн үйл ажиллагааг батлагдсан тогтолцооноос өөр тогтолцоонд гүйцэтгэхийг хориглох заалт хуульд оруулах
2	Зөрчлийн тухай хуульд энэ асуудал тусгагдсан эсэх	тийм	Зөрчлийн тухай хуулийн 12.2.1.1. Төрөл бүрийн масштаб, бүх ангиллын газрын зураг, геодезийн хэмжилт, магадлан хэмжилтийг: солбилцол, өндрийн нэгдсэн тогтолцоонд нийцүүлээгүй, эсхүл хийгээгүй тохиолдолд торгоно.
3	Энэхүү асуудлыг байнга, тодорхой хугацаанд шинэчлэх зохицуулалт бий эсэх	тийм	Хэрэгцээ шаардлага нь БНБД -д орсон тул хуулинд тусгах
4	Энэхүү асуудлын тоо, хэмжээ		ЗГ-ын 2022 оны 267-р тогтоолоор ITRF2020 солбицлын тогтолцоонд хэмжилт зураглалын ажил хийхээр баталсан
5	Улсын төсвөөр хийсэн ажлын мэдээ		GNSS-ын 43 БАСС станцын солбицол, хурдны утгыг тэгшитгэн бодсон.
6	Орон нутгийн төсвөөр хийсэн ажлын мэдээ	үгүй	
7	Бусад байгууллагын /дотоодын болон гадаадын/ төсвөөр хийсэн ажлын мэдээ	үгүй	
8	Үүнийг хэрэглэгчийн талаарх мэдээлэл		Монгол Улсад Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж- (200 гаруй компани) болон бусад салбар
9	Хэрхэн хэрэглээнд гаргаж байгаа талаарх мэдээлэл		ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/249 дугаар тушаалаар хэрэглээнд гаргасан.

**Солбицлын дэд тогтолцооны нөхцөл байдлын судалгаа**

*Хүснэгт 7*

д/д	Хуулийн хэрэгжилтийн судалгаа	Тийм/ үгүй	Тайлбар /зүйл, заалтын дугаар, хэрэгцээ, шаардлагыг энд бичих/
1	Геодези, зураг зүйн тухай хуулиар зохицуулсан зүйл, заалт, хэсэг		
1.1	Нэр томъёоны тодорхойлолт хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /3 дугаар зүйл/	үгүй	“Солбицлын дэд тогтолцоо” гэсэн нэр томъёог хуульд шинээр нэмж оруулах
1.2	Геодези, зураг зүйн үйл ажиллагаа хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /4 дүгээр зүйл/	үгүй	Төв, суурин газар бүрт том масштабын дэвсгэр зураг үйлдэхэд солбицлын дэд тогтолцоо шаардлагатай тул хуульд тодорхойлох, үйл ажиллагааг зааж оруулах
1.3	Төрийн байгууллагын чиг үүрэгт тусгагдсан эсэх /5 дугаар зүйл/	үгүй	Боловсруулах ажлыг зохион байгуулах, батлах, хэрэгжүүлэх, хянах зохицуулалтыг хуульд нэмж тусгах
1.4	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний чиг үүрэгт тусгагдсан эсэх /6 дугаар зүйл/	үгүй	Боловсруулах ажлыг гүйцэтгэх, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах үүргийг хуульд нэмж тусгах
1.5	Санхүүжилтийн асуудал тусгагдсан эсэх /7 дугаар зүйл/	үгүй	Орон нутгийн төсвөөр хийхээр хуульд тусгах
1.6	ГЗЗ-н мэдээллийн улсын нэгдсэн санд хэрхэн шилжүүлэх, хадгалах, түгээх талаар тусгагдсан эсэх		9.1 9.2 9.3 Эдгээр заалтуудад шаардлагатай өөрчлөлт оруулж шинэчилэн найруулах
1.7	Энэ асуудлаар хуулийн тусгайлсан зохицуулалт байгаа эсэх	үгүй	
1.8	Хориглосон зохицуулалт хуулинд байгаа эсэх /12 дугаар зүйл/	үгүй	Төв суурин газарт гүйцэтгэж байгаа геодези, зураг зүйн үйл ажиллагааг батлагдсан тогтолцооноос өөр тогтолцоонд гүйцэтгэхийг хориглох заалт хуульд оруулах
2	Зөрчлийн тухай хуульд энэ асуудал тусгагдсан эсэх		3.3
3	Энэхүү асуудлыг байнга, тодорхой хугацаанд шинэчлэх зохицуулалт бий эсэх	үгүй	Улсын солбицлын тогтолцоог шинэчлэхэд тухай бүрт тогтолцоо хоорондын хөрвүүлэлтийн утгуудыг шинэчлэх талаар хуульд тусгах
4	Энэхүү асуудлын тоо, хэмжээ		Нийслэл, 21 аймаг, 330 сум, томоохон суурин
5	Улсын төсвөөр хийсэн ажлын мэдээ		Нийслэл Улаанбаатар хот /5 тэрбум/, Өмнөговь аймгийн 4 сум /1.2 тэрбум/
6	Орон нутгийн төсвөөр хийсэн ажлын мэдээ	үгүй	
7	Бусад байгууллагын /дотоодын болон гадаадын/ төсвөөр хийсэн ажлын мэдээ		Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар, Өмнөговь аймгийн ГХБХБГ
8	Үүнийг хэрэглэгчийн талаарх мэдээлэл		Дэд бүтэц, Хот төлөвлөлт, Газрын харилцааны салбарт үндэслэл болно.

9	Хэрхэн хэрэглээнд гаргаж байгаа талаарх мэдээлэл	Улаанбаатар хотын солбицлын дэд тогтолцоог ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/331 дугаар тушаалаар батлан, хэрэглээнд нэвтрүүлсэн.
---	--	---

Улсын өндрийн сүлжээний талаарх судалгааг 8-р хүснэгтэд, гравиметрийн сүлжээний талаарх судлагааг 9-р хүснэгтэд тус тус үзүүлэв.

### Өндрийн сүлжээний нөхцөл байдлын судалгаа

Хүснэгт 8

д/д	Хуулийн хэрэгжилтийн судалгаа	Тийм/үгүй	Тайлбар /зүйл, заалтын дугаар, хэрэгцээ, шаардлагыг энд бичих/
1	Геодези, зураг зүйн тухай хуулиар зохицуулсан зүйл, заалт, хэсэг		
1.1.	Нэр томъёоны тодорхойлолт хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /3 дугаар зүйл/	үгүй	“Өндрийн сүлжээ” гэж бусад сүлжээнээс ялган шинээр нэмж томъёолох шаардлагатай. Энэ нь цаашид энэ төрлийн ажил төлөвлөх, гүйцэтгэх, санхүүжүүлэхэд зайлшгүй хэрэгтэй.
1.2.	Геодези, зураг зүйн үйл ажиллагаа хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /4 дүгээр зүйл/	тийм	4.1.1-д “геодезийн сүлжээ байгуулах” гэсэн ерөнхий нэрээр орсон. “Өндрийн сүлжээ байгуулах” гэсэн үйл ажиллагааг шинээр нэмж оруулах шаардлагатай.
1.3.	Төрийн байгууллагын чиг үүрэгт тусгагдсан эсэх /5 дугаар зүйл/	үгүй	Үүнийг төлөвлөх, санхүүжүүлэх, зохион байгуулах, хянах ажлыг хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт тусгах шаардлагатай. Мөн энэ ажлын захиалагч нь хэн байхыг хуульд тусгах.
1.4.	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний чиг үүрэгт тусгагдсан эсэх /6 дугаар зүйл/	үгүй	Энэ ажлыг геодезийн тусгай зөвшөөрөл бүхий этгээд гүйцэтгэх тухай заалт оруулах
1.5.	Санхүүжилтийн асуудал тусгагдсан эсэх /7 дугаар зүйл/	үгүй	Улсын төсвөөр санхүүжүүлнэ гэж хуульд шинээр нэмж тусгах
1.6.	ГЗЗ-н мэдээллийн улсын нэгдсэн санд хэрхэн шилжүүлэх, хадгалах, түгээх талаар тусгагдсан эсэх /9 дугаар зүйл/	тийм	9.1 9.2 9.3 “геодезийн сүлжээ” гэсэн ерөнхий нэрээр орсон. Өндрийн сүлжээний хэмжилтийн анхдагч өгөгдөл, урьдчилсан бодолт, эцсийн тэгшитгэн бодолтын үр дүнг, өндрийн каталог гэж ялгаж оруулах
1.7.	Энэ асуудлаар хуулийн тусгайлсан зохицуулалт байгаа эсэх	үгүй	
1.8.	Хориглосон зохицуулалт хуулинд байгаа эсэх /12 дугаар зүйл/	үгүй	
2	Зөрчлийн тухай хуульд энэ асуудал тусгагдсан эсэх		8.2.3 3.3
3	Энэхүү асуудлыг байнга, тодорхой хугацаанд шинэчлэх зохицуулалт бий эсэх	үгүй	Хэвийн үед 15 жил тутамд, хүчтэй газар хөдлөлт болсон тухай бүрд давтан хэмжих шаардлагатай тул ийм заалтыг хуульд шинээр нэмж оруулах.

4	Энэхүү асуудлын тоо, хэмжээ		Өндрийн I-р ангийн сүлжээ 2 полигон, 7 шугам, 472 км, Өндрийн II-р ангийн сүлжээ 13 полигон, 46 шугам, 14000 км шугамын урттай
5	Улсын төсвөөр хийсэн ажлын мэдээ		- Өндрийн I ангийн сүлжээний хэмжилтийг /1,600.4 сая төг/ гүйцэтгэсэн. - Геодезийн сүлжээний эхлэл цэгийг өндрийн I ангийн сүлжээтэй холбох хэмжилтийг /76.7 сая төг/ гүйцэтгэсэн.
6	Орон нутгийн төсвөөр хийсэн ажлын мэдээ	үгүй	
7	Бусад байгууллагын /дотоодын болон гадаадын/ төсвөөр хийсэн ажлын мэдээ	үгүй	
8	Үүнийг хэрэглэгчийн талаарх мэдээлэл		Өндрийн үндэслэл болно. Геологи, уул уурхайн салбар, Эрчим хүчний салбар, Хот төлөвлөлт болон барилга, хот байгуулалтын салбар, Зам тээврийн салбар, Батлан хамгаалах салбар, /Батлан хамгаалах /
9	Хэрхэн хэрэглээнд гаргаж байгаа талаарх мэдээлэл		Өндрийн I ангийн сүлжээний цэгийн солбицол, өндрийн жагсаалтыг ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/81 дугаар тушаалаар батлан хэрэглээнд нэвтрүүлсэн.

### Гравиметрийн сүлжээний нөхцөл байдлын судалгаа

Хүснэгт 9

Д/д	Хуулийн хэрэгжилтийн судалгаа	Тийм/ үгүй	Тайлбар /зүйл, заалтын дугаар, хэрэгцээ, шаардлагыг энд бичих/
1	Геодези, зураг зүйн тухай хуулиар зохицуулсан зүйл, заалт, хэсэг		
1.1	Нэр томъёоны тодорхойлолт хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /3 дугаар зүйл/	үгүй	“Гравиметрийн сүлжээ” гэж бусад сүлжээнээс ялган шинээр нэмж томъёолох шаардлагатай. Энэ нь цаашид энэ төрлийн ажил төлөвлөх, гүйцэтгэх, хянах, санхүүжүүлэхэд зайлшгүй хэрэгтэй.
1.2	Геодези, зураг зүйн үйл ажиллагаа хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /4 дүгээр зүйл/		4.1.1-д “геодезийн сүлжээ байгуулах” гэсэн ерөнхий нэрээр орсон. “Гравиметрийн сүлжээ байгуулах” гэсэн үйл ажиллагааг шинээр нэмж оруулах шаардлагатай.
1.3	Төрийн байгууллагын чиг үүрэгт тусгагдсан эсэх /5 дугаар зүйл/		Үүнийг төлөвлөх, санхүүжүүлэх, зохион байгуулах, хянах ажлыг хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт тусгах шаардлагатай. Мөн энэ ажлын захиалагч нь хэн байхыг хуульд тусгах.
1.4	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний чиг үүрэгт тусгагдсан эсэх /6 дугаар зүйл/	үгүй	Энэ ажлыг гүйцэтгэх үүргийг тусгах
1.5	Санхүүжилтийн асуудал тусгагдсан эсэх /7 дугаар зүйл/	үгүй	Улсын төсвөөр санхүүжүүлнэ гэж хуульд шинээр нэмж тусгах

1.6	ГЗЗ-н мэдээллийн улсын нэгдсэн санд хэрхэн шилжүүлэх, хадгалах, түгээх талаар тусгагдсан эсэх		9.1 9.2 9.3 “геодезийн сүлжээ” гэсэн ерөнхий нэрээр орсон. Гравиметрийн сүлжээний хэмжилтийн анхдагч өгөгдөл, урьдчилсан бодолт, эцсийн тэгшитгэн бодолтын үр дүн, хүндийн хүчний утгын каталог гэж ялгаж оруулах
1.7	Энэ асуудлаар хуулийн тусгайлсан зохицуулалт байгаа эсэх	үгүй	
1.8	Хориглосон зохицуулалт хуулинд байгаа эсэх /12 дугаар зүйл/	үгүй	
2	Зөрчлийн тухай хуульд энэ асуудал тусгагдсан эсэх		8.2.3 3.3
3	Энэхүү асуудлыг байнга, тодорхой хугацаанд шинэчлэх зохицуулалт бий эсэх	үгүй	Хэвийн үед 15 жил тутамд, хүчтэй газар хөдлөлт болсон тухай бүрд давтан хэмжих шаардлагатай тул ийм заалтыг хуульд шинээр нэмж оруулах.
4	Энэхүү асуудлын тоо, хэмжээ		31 цэг бүхий гравиметрийн I анги, 103 цэг бүхий гравиметрийн II ангийн сүлжээг байгуулсан.
5	Улсын төсвөөр хийсэн ажлын мэдээ		Үнэмлэхүй гравиметрийн хэмжилтийг /50 сая төг/ гүйцэтгэсэн.
6	Орон нутгийн төсвөөр хийсэн ажлын мэдээ	үгүй	
7	Бусад байгууллагын /дотоодын болон гадаадын/ төсвөөр хийсэн ажлын мэдээ		ГЗБГЗЗЕГ болон Япон улсын Гео-орон зайн мэдээллийн агентлагтай хамтын ажиллагааны Санамж бичиг солилцож Гравиметрийн эхлэл цэг, гравиметрийн I ангийн сүлжээний 2 цэгт үнэмлэхүй гравиметрийн хэмжилт гүйцэтгэсэн.
8	Үүнийг хэрэглэгчийн талаарх мэдээлэл		Геологи, уул уурхайн салбар, Зам тээврийн салбар, Батлан хамгаалах салбар, /Батлан хамгаалах /
9	Хэрхэн хэрэглээнд гаргаж байгаа талаарх мэдээлэл		Гравиметрийн сүлжээний цэгийн хүндийн хүчний хурдатгалыг Геодези, зураг зүйн улсын нэгдсэн мэдээллийн сангаас хэрэглэгчдэд түгээдэг.

Гэвч Геодези, зураг зүйн тухай хуульд геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах солбицол, өндөр, тусгаг, масштаб, дүрслэх хавтгайн тогтолцоог боловсруулах, батлах, мөрдөх талаар тусгасан байдаг боловч солбицлын дэд тогтолцоо, улсын солбицлын тогтолцоо, гравиметрийн сүлжээ, өндрийн сүлжээ гэсэн нэр томъёо, үйл ажиллагааг тодорхойлоогүй, энэ төрлийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, санхүүжүүлэх асуудлыг зохицуулаагүй байна.

#### Үнэлгээ:

Монгол Улс дэлхий нийтэд ашиглаж буй байрлал, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжсэн боловч газрын харилцаа, барилга, дэд бүтэц, уул уурхай, байгаль орчин, зам, тээвэр зэрэг салбарт газрын зураг, тоон мэдээлэлд тулгуурлан хийгдсэн

инженерчлэлийн тооцоо, судалгаанд гарч буй зөрүүг шийдвэрлэх зорилгоор хот суурин, бусад газарт солбицлын дэд тогтолцоог хэрэгжүүлж дэвсгэр зургаар хангах, нийтийн хэрэгцээнд ашиглуулах практик шаардлага бий болж байна.

Геодези, зураг зүйн тухай хуульд уламжлалт геодезийн сүлжээ болох байрлалын, өндрийн, гравиметрийн сүлжээний талаар тусгайлан сүлжээ гэж тусгаагүй харин геодезийн сүлжээ гэсэн нэг ерөнхий нэрийн доор нэгтгэн оруулж ерөнхийд нь зохицуулсан байна. Тухайлбал:

- “Сүлжээ” гэдэг үг геодезийн сүлжээ гэсэн ерөнхий нэрээр 3 удаа дурдагдсан;
- “Байрлал” гэдэг үг 3 удаа дурдагдсан хэдий ч байрлалын сүлжээ гэсэн утга илэрхийлээгүй;
- “Өндөр” гэдэг үг 5 удаа дурдагдсан ч өндрийн сүлжээ гэсэн утга илэрхийлээгүй;
- “Гравиметр” гэдэг үг гравиметрийн хэмжилт хийх гэж 1 удаа дурдагдсан байна.

Иймд Геодези, зураг зүйн тухай хуульд “Улсын солбицлын тогтолцоо”, “Солбицолын дэд тогтолцоо”, “Гравиметрийн сүлжээ”, “Өндрийн сүлжээ” гэсэн нэр томъёо, үйл ажиллагааг тодорхойлох, энэ төрлийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, санхүүжүүлэх асуулыг зохицуулах зайлшгүй шаардлагатай.

### **3.3.Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3.Геодезийн цэг тэмдэгттэй холбоотой хуулийн зохицуулалт практикт хэрэгжиж байгаа эсэх?**

Геодезийн байнгын цэг, тэмдэгт гэж геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэс болох байрлал, өндөр, хүндийн хүчний хурдатгал зэрэг орон зайн гурав болон түүнээс дээш хэмжээсээр утга нь тодорхойлогдсон, газрын гадарга, хэвлий, барилга байгууламж зэрэг хөдөлгөөнгүй биетэд бэхлэгдсэн төв болон түүний гаднах тэмдэглээсийг хэлнэ.

Геодезийн сүлжээг цэгийн ямар утга тодорхойлох хэмжилт хийхээс хамааран байрлалын /триангуляци, полигонометр/, өндрийн / I, II, III, IV анги/, гравиметрийн, GPS-ийн сүлжээ гэж ангилдаг.

Монгол улсад дээрх 5 төрлийн сүлжээний 25000 гаруй цэг байдаг бөгөөд улс орны хил заагийн байршлыг тодорхойлохоос эхлэн жирийн иргэдийн хашааны булангийн цэгийн байршлыг тодорхойлох хүртэлх бүхий л төрлийн ажилд геодезийн байнгын цэг тэмдэгтийг ашигладаг.

Байнгын цэг тэмдэгтийн судалгааг Хүснэгт 10-д, GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станц нөхцөл байдлыг судалгааг Хүснэгт 11-д үзүүллээ.

#### ***Геодезийн цэг тэмдэгтийн нөхцөл байдлын судалгаа***

*Хүснэгт 10*

Д/д	Хуулийн хэрэгжилтийн судалгаа	Тийм/үг үй	Тайлбар /зүйл, заалтын дугаар, хэрэгцээ, шаардлагыг энд бичих/
1	Геодези, зураг зүйн тухай хуулиар зохицуулсан зүйл, заалт, хэсэг	тийм	10 дугаар зүйл бүхэлдээ энэ асуудлыг агуулсан.
1.1	Нэр томъёоны тодорхойлолт хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /3 дугаар зүйл/	тийм	3.1.6. 3.1.7 энэ заалтыг шинэчлэн найруулах шаардлагатай.
1.2	Геодези, зураг зүйн үйл ажиллагаа хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /4 дүгээр зүйл/	үгүй	Дангаараа тусгагдаагүй боловч 4.1.1 геодезийн сүлжээ байгуулах ажилд цэг тэмдэгт судлах, байгуулах нь зайлшгүй багтдаг холбогдох дүрмээр зохицуулдаг.  Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг байгуулах, сэргээх, тоолох, бүртгэх,

			хадгалах, хамгаалах, шалгах талаар хуулийн үйл ажиллагаа хэсэгт нэмж оруулах шаардлагатай.
1.3	Төрийн байгууллагын чиг үүрэгт тусгагдсан эсэх /5 дугаар зүйл/	тийм	5.8.2
1.4	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний чиг үүрэгт тусгагдсан эсэх /6 дугаар зүйл/	тийм	10.2, 10.3 заалтуудад тус хуулийн 6 дугаар зүйлд заасан байгууллага нь геодезийн цэг тэмдэгт байгуулсан бол тухайн сум дүүргийн засаг дарга, хил хамгаалах газрын харьяа тусгай ангиудад хүлээлгэн өгөх үүрэгтэй. Цэг тэмдэгтийн хамгаалалтын зурвасыг тогтоох зохицуулалтыг оруулах.
1.5	Санхүүжилтийн асуудал тусгагдсан эсэх /7 дугаар зүйл/	үгүй	Цэг, тэмдэгт байгуулах нь дангаараа бие даасан үйл ажиллагаа биш харин бусад геодезийн ажлын бүрдэлд ордог үйл ажиллагаа юм. Иймд санхүүжилтийн асуудлыг хуульд тусгайлан тусгах шаардлагагүй.
1.6	ГЗЗ-н мэдээллийн улсын нэгдсэн санд хэрхэн шилжүүлэх, хадгалах, түгээх талаар тусгагдсан эсэх	үгүй	9.1- д заасан ГЗЗ-н мэдээллийн улсын нэгдсэн санд хамаарах боловч хуульд нарийвчлан тусгаагүй, холбогдох дүрэм журмаар зохицуулдаг.
1.7	Энэ асуудлаар хуулийн тусгайлсан зохицуулалт байгаа эсэх	тийм	10.1 Геодезийн байнгын цэг, тэмдэгт нь төрийн өмч байна.
1.8	Хориглосон зохицуулалт хуулинд байгаа эсэх /12 дугаар зүйл/	тийм	12.1.2. геодезийн байнгын цэг, тэмдэгтийг устгах, гэмтээх, хэмжилт хийх нөхцөлийг алдагдуулах;
2	Зөрчлийн тухай хуульд энэ асуудал тусгагдсан эсэх	тийм	Зөрчлийн тухай хуулийн 8.2.3. 12.2.4, 12.2.5, 12.2.7, 12.3.2
3	Энэхүү асуудлыг байнга, тодорхой хугацаанд шинэчлэх зохицуулалт бий эсэх	үгүй	
4	Энэхүү асуудлын тоо, хэмжээ		Монгол улсын хэмжээнд байгуулсан 23000 орчим геодезийн цэг тэмдэгт байна
5	Улсын төсвөөр хийсэн ажлын мэдээ		Тодорхойлох боломжгүй
6	Орон нутгийн төсвөөр хийсэн ажлын мэдээ		Тодорхойлох боломжгүй
7	Бусад байгууллагын /дотоодын болон гадаадын/ төсвөөр хийсэн ажлын мэдээ		Тодорхойлох боломжгүй
8	Үүнийг хэрэглэгчийн талаарх мэдээлэл		Монгол Улсад Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж- (200 гаруй компани)
9	Хэрхэн хэрэглээнд гаргаж байгаа талаарх мэдээлэл		<a href="https://nsdi.gov.mn/">https://nsdi.gov.mn/</a> цахим системээр дамжуулан цэг тэмдэгтийн мэдээллийг хэрэглэгчдэд түгээж байна.

Үнэлгээ:

Геодези, зураг зүйн тухай хуульд геодезийн байнгын цэг тэмдэгт түүний хамгаалалтын бүсийн талаар огт дурдаагүй, мэдээллийн санд төвлөрүүлэх талаар зохицуулалтгүй байна

Геодезийн сүлжээ байгуулах ажилд цэг тэмдэгт судлах, байгуулах нь зайлшгүй багтдаг тул Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг байгуулах, сэргээх, тоолох, бүртгэх, хадгалах, хамгаалах, шалгах талаар хуульд нэмж тусгах шаардлагатай.

### **3.4.Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4. Геодезийн багаж баталгаажуулалттай холбоотой зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?**

Хэмжилзүйн лаборатори нь ОХУ-ын мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар анх 1980 онд байгуулагдсан. БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дэргэдэх Улсын стандартын газрын /тухайн үеийн нэрээр/ 1989 оны 69 дүгээр тогтоолоор "Геодезийн хэмжих хэрэгслийг шалгах, засварлах, баталгаажуулах" салбарын эрх олгосон. Геодезийн хэмжлийн багаж хэрэгслийг шалгаж баталгаажуулах, геодезийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах чиглэлээр улсын хэмжээнд вйл ажиллагаагаа явуулдаг. Лабораторийг шинэчлэх вйл ажиллагаа 2 удаа явагдсан бөгөөд 2000 онд сүүлийн шинэчлэлийг хийсэн. Лаборатори нь "Геодези, зураг зүйн тухай" Монгол улсын хуулийн 5.5.5 дахь заалтын дагуу геодезийн хэмжих хэрэгсэлд шалгалт, тохируулга, баталгаажуулалт хийх үүргийг хүлээсэн юм.

Стандартчилал, хэмжилзүйн газраас лабораторийг ISO/IEC 17025:2005 (MNS ISO/IEC 17025:2007) стандартын шаардлагыг хангасан, геодезийн хэмжилзүйн багаж хэрэгсэлд шалгалт тохируулга гүйцэтгэх техникийн чадавхитай, лабораторийн чанарын удирдлагын тогтолцоотой болохыг гэрчилэн Итгэмжлэлийн гэрчилгээ олгосон.

2022 онд MNS ISO/IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт, тохируулгын лабораторийн чадавхид тавигдах ерөнхий шаардлага” стандартыг хангасан тул геодезийн хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт гүйцэтгэх техникийн чадавхи, чанарын удирдлагын тогтолцоотой болохыг гэрчлэн Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/164 дүгээр тушаалаар итгэмжлэгдсэн.

Үндэсний итгэмжлэлийн төв нь Ази, номхон далайн орнуудын бүс нутгийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага /APAC - Asia pacific accreditation cooperation/-ын жинхэнэ гишүүн бөгөөд эдгээр хамтын ажиллагааны байгууллагуудын Харилцан хүлээн зөвшөөрөх олон талт хэлэлцээрт нэгдэн Монгол Улсын төлөөлж ажилладаг.

Тус төвөөс MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу итгэмжлэгдснээрээ шалгалт баталгаажуулалт гүйцэтгэх техникийн чадавхи, чанарын удирдлагын тогтолцоотой болохыг гэрчилэн манай лабораторийн үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдээд байна.

Хэмжилзүйн лаборатори нь геодезийн бvх төрлийн түвшин, өнцөг хэмжих хэрэгслийг шалгаж тохиргоо хийх зориулалт бүхий коллиматорийн систем, өндөр нарийвчлалтай нивелирдлэгийн ажилд зориулагдсан инвар рейк шалгах МК-1 компаратор, бусад шалгалтын электрон тоног төхөөрөмж, компьютерээр тоноглогдсон юм. Солонгос улсад үйлдвэрлэсэн SY AL32 маркийн 1 км нүүлтийн дундаж квадрат алдаа нь 1мм-ийн нарийвчлалтай автомат нивелир, Япон улсын SOKKIA фирмд үйлдвэрлэсэн PowerSet2010 маркийн 2 секундын өнцөг хэмжлийн нарийвчлалтай,  $\pm(2\text{мм}+2\text{ppm} \times D)\text{мм}$ -ийн зай хэмжлийн нарийвчлалтай эталон электрон тахеометр багажаар хангагдсан.

Тоног төхөөрөмжүүд нь дуу чимээ, доргилт, чичирхийллээс хамгаалагдсан, 2,5- 5,0 м-ийн гүн суурь дээр байгуулагдсан болно. 1 давхрын 24 м урт хонгил геодезийн лазер хэмжих хэрэгслийг шалгахад ашиглагдаж байна. 2009 онд GPS болон бүх төрлийн зай хэмжлийн багажуудыг шалгах зориулалт бүхий зай хэмжлийн полигоныг Төв аймгийн Номтын аманд байгуулсан.

Геодезийн хэмжилт гүйцэтгэх багаж хэрэгслийг баталгаажуулах нь нэг талаас гүйцэтгэж байгаа ажлын үр дүн, чанарт шууд нөлөөлдөг, нөгөө талаас хэмжилтийг үнэн зөв хийж байгаагийн баталгаа болдог.

Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.5.5-д геодези, зураг зүйн хэмжлийн багаж хэрэгслийг шалгах, баталгаажуулах эрхийг Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр заасан.

Харин Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу Стандарт, хэмжил зүйн газар геодезийн хэмжлийн багаж баталгаажуулах эрхийг хувийн аж ахуйн нэгжид олгосноор хуулийн зөрчил үүссэн.

Геодезийн хэмжих хэрэгслийн төрөл:



Монгол Улсад 13 төрлийн 19545 ширхэг геодезийн хэмжлийн багаж бүртгэгдсэн байгаагаас 2028 нь хэмжил зүйн лабораториар баталгаажсан, хугацаа дууссан 4191 багаж, архивт бүртгэгдсэн 13319 багаж байна.

#### Үнэлгээ:

Геодези, зураг зүйн тухай хууль болон Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн заалтууд хоорондоо зөрчилтэй байна.

Геодезийн хэмжлийн багаж хэрэгслийг шалгаж, баталгаажуулахын өмнө ихэнхдээ засварлах, тохируулах үйл ажиллагаа хийгддэг. Энэ нь төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг биш харин төрийн бус байгууллага, хувийн аж ахуйн нэгжийн гүйцэтгэх үйл ажиллагаа юм. Энэ талаар хуульд зохицуулалт байхгүй байна.

Техник, технологи хөгжсөн өнөө үед геодезийн багаж хэрэгслийг шалгах, баталгаажуулах үйл ажиллагаа бараг хүний оролцоогүй буюу автоматаар хийгддэг болсон. Хэдий хуулийн зохицуулалтгүй ч гэсэн манай улс ийм автомат системийг хөгжүүлж байна.

Иймд геодезийн хэмжилийн багаж хэрэгслийг засварлах, тохируулах, шалгах, баталгаажуулах үйл ажиллагааг тодорхойлох болон түүнд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагын зохицуулалтыг хуульд тусгах, бусад хууль хоорондын зөрчлийг арилгах практик шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

### **3.5.Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5.Газар зүйн нэртэй холбоотой зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?**

Газар зүйн нэр нь тухайн улс орны соёл, уламжлал, угсаатан зүй, газар зүйн өвөрмөц онцлогийг өөртөө тусгаж, эдийн засаг, нийгмийн харилцаа, үндэсний аюулгүй байдлыг хангах зэрэгт чухал ач холбогдолтой байдаг.

Геодези, зураг зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйл бүхэлдээ газар зүйн нэрийн харилцааг зохицуулдаг ба мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасны дагуу газар зүйн нэрийг Улсын Их Хурлаас баталдаг. Түүнчлэн Газар зүйн нэр нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14-д зааснаар биет бус соёлын өвд тооцогддог.

Монгол улс ЮНЕСКО-гийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц”-д 2005 онд нэгдэн орсон бөгөөд энэхүү конвенцид нэгдэн орсон улс бүр өөрийн нутаг дэвсгэр дээрх соёлын биет бус өвийг хамгаалах үүрэг хүлээдэг.

Монголчууд эрт дээр үеэс нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдарч, алс хол аян жин тээх, эзэмшил газар нутгаа сахин хамгаалах, алс газар дайлаар мордохдоо уул, ус, газар нутгаа тахин шүтэж, дээдлэн хүндэлж уул, овоо, ухаа, гүвээ, дов толгод, гол, горхи нэг бүрийг нэрлэн газар зүйн нэрийн арвин сан хөмрөг бүрдүүлэн ирсэн уламжлалтай.

1925 онд Зөвлөлт Холбоот Улсын /хуучнаар/ Шинжлэх Ухааны Академийн дэргэд Монгол газар зүйн нэрийн комисс байгуулагдаж, газар зүйн нэрийн уйгаржин-монгол бичгийг тайлах аргачлалыг боловсруулж байжээ. Үүний дүнд “Орчин цагийн Монголын газар зүйн нэр” бүтээл хэвлэгдсэн нь Монгол орны газар зүйн нэрийг судлахад ихээхэн чухал баримт бичиг болжээ.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөөс шалтгаалан ард түмний суурьшилд ихээхэн өөрчлөлт гарах болж түүхийн уламжлал бүхий газар зүйн нэрүүд нь мартагдах, андуу ташаа нэрлэгдэх, өөрчлөгдөх болсон тул анх 1949 онд Сайд нарын Зөвлөлийн (хуучин нэрээр) “Газар зүйн нэрийг дур мэдэн өөрчлөх явдлыг хориглох тухай”, 1961 онд “Комисс байгуулах тухай” тогтоолууд гарч, газар зүйн нэрийг тодотгон тогтоох, цуглуулах талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад албан даалгавар өгч ажилласан байна.

Монгол улсад Газрын зураглалын байгууллага анх 1970 онд байгуулагдсан бөгөөд энэ үеэс газрын зурагт газар зүйн нэрийг үнэн зөв тэмдэглэх асуудал хурцаар тавигдаж, тус газар нь Шинжлэх Ухааны Академийн хэл судлалын хүрээлэнгийн эрдэмтэдтэй хамтран ажиллаж, түүхэн газар зүйн нэрийг сэргээх, гадаад хэлэнд нэрийг галиглах, зөв бичиж газрын зураг, атласт тусгаж хэрэглэх, нийтийн хүртээл болгох зэрэг асуудлуудыг хамтран шийдвэрлэж ирсэн байна.

1980 онд Сайд нарын Зөвлөл (хуучин нэрээр)-өөс “БНМАУ-ын Газар зүйн нэрийг тодосгон тогтоох ажлыг зохион байгуулах тухай” албан даалгаврыг Улсын геодези, зураг зүйн газар (хуучин нэрээр), аймгуудын намын хороо, захиргааны дарга нарт хүргүүлжээ.

Тус албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1980-1984 онд Геодези, зураг зүйн газар /хуучнаар/-аас Монгол орны бүх нутаг дэвсгэрт газар зүйн нэрийн хээрийн судалгаа явуулан уул, нуруу, хөндий, гол, худаг, булаг зэрэг газар зүйн 240 мянга гаруй нэрийг нутгийн уугуул иргэдтэй хамтран тодотгон тогтоож, 1987-1990 онд 1:100000-ны масштабтай 1210 хуудас байр зүйн зурагт тэмдэглэн аймаг, сумын засаг захиргаа болон

Улсын газар нутгийн нэрийн комиссоор хэлэлцүүлэн баталгаажуулж, 1945 оны үед Зөвлөлт холбоот улсын цэргийн ангиудаас хийж өгсөн Монгол орны нутаг дэвсгэрийг бүхэлд нь бүрхсэн 1:100000-ны масштабтай орос байр зүйн зургийг Монгол болгон хэвлэж, улсыг батлан хамгаалах, нэгдэл, сангийн аж ахуйг байгуулах, газар тариалан, хөдөө аж ахуйг хөгжүүлэх, уул уурхайн ашигт малтмалыг хайж илрүүлэх, хот тосгон, аймаг сумын төв байгуулах, зэрэг улс ардын аж ахуйн бүхий л салбарыг хөгжүүлэхэд суурь, дэвсгэр зургаар хангасан байдаг.

Тэр цагаас хойш эдгээр Монгол газар нутгийн нэрийг геодези, зураг зүйн үйл ажиллагаа болон газрын зураг, атласт тусган хэрэглэж байна

2010-2012 онуудад Дорноговь, Дундговь аймгуудад газар зүйн нэрийн хээрийн тодруулалт ажил хийгдэж байсан бөгөөд уг ажлын тайлангууд нь ГЗБГЗЗЕГ-т хадгалагдаж байна. Дорноговь аймгийн Алтанширээ, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах, Сайхандулаан, Сайншанд сумуудад 9974 нэр тодруулснаас 114 нэр шинээр, 5 нэр зөрүүтэй байсныг, Дундговь аймгийн Адаацаг, Баянжаргалан, Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Өлзийт, Өндөршил, Сайнцагаан, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумууд болон Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Их хэт сумуудад 1203 нэр тодруулснаас 239 нэр шинээр, 29 нэр зөрүүтэй байсныг тус тус тодотгон тогтоосон байна. Энэхүү ажлын үр дүнд 12005 ширхэг газар зүйн нэрийн мэдээллийн санг Excel, ArcGIS програм дээр үүсгэсэн байна.

2003 онд Монгол орны 213 мянга гаруй нэрийг Улсын Их Хурлын тогтоолоор батлуулан, газар зүйн нэрийн зүйлчилсэн 8 толийг бэлтгэж, хэвлүүлэн нийтийн хүртээл болгож, албан бичиг, ном, товхимол, газрын зураг болон бусад баримт бичигт мөрдүүлэх зорилгоор аймгуудын газрын албадад хүргүүлэн ашиглаж байна.

Аймаг, нийслэл тус бүрээр гаргасан газар зүйн нэрийн тоо

*Хүснэгт 12*

д/д	Аймаг, хотын нэр	Талбай /мян.км.кв/	Сумы н тоо	Тодотгон тогтоосон нэрийн тоо	Шинээр өгсөн нэр	Батлуулах нэрийн тоо
1.	Архангай	54.8	17	16896	-	16896
2.	Баян-Өлгий	45.7	12	9492	167	9659
3.	Баянхонгор	115.8	18	16619	391	17010
4.	Булган	49.2	13	9748	32	9780
5.	Говь-Алтай	140.7	17	18093	16	18109
6.	Дорноговь	111.0	13	11143	-	11143
7.	Дорнод	123.5	14	9870	-	9870
8.	Дундговь	78.0	15	10819	-	10819
9.	Завхан	81.9	22	23302	27	23329
10.	Өвөрхангай	63.0	19	11231	-	11231
11.	Өмнөговь	164.9	14	13577	-	13577
12.	Сүхбаатар	82.0	12	7717	144	7861
13.	Сэлэнгэ	42.8	17	8988	-	8988
14.	Төв	78.3	25	11975	-	11975
15.	Увс	69.0	18	12330	51	12381
16.	Ховд	76.0	16	12003	-	12003
17.	Хөвсгөл	100.8	19	24409	-	24409
18.	Хэнтий	82.0	18	12078	-	12078
19.	УБ	4.7	-	1220	-	1220
<b>Бүгд</b>		<b>1564.1</b>	<b>299</b>	<b>241510</b>	<b>828</b>	<b>242338</b>

2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр “Хаягжуулалтын тухай” хууль, Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 280 дугаар тогтоолоор “Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам”, 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 1 дүгээр

тогтоолоор “Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягийн тэмдэглэгээнд тавих шаардлага” MNS5283:2014 стандартыг батлуулав. Эдгээр хууль, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хаягийн зургийг хийхдээ хот суурингаас бусад хөдөө орон нутагт орших гудамж, зам, талбай, хотхоны зохион байгуулалтад ороогүй өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн газар болон түүн дээрх үл хөдлөх эд хөрөнгөд газар зүйн нэрийн толиор баталгаажсан нэрийг үндэслэн хаягжуулж байгаа юм.

Хаягийн мэдээллийн мэдээллийн систем байгуулах ажлын хүрээнд 21 аймаг, 330 сум, нийслэл хотын хэмжээнд хийгдсэн 1:100000 масштабтай хаягийн зурагт УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан газар зүйн нэрийг ашигласан бөгөөд мэдээллийн сан үүсгэн байгууллагын орон зай өгөгдлийн системд 2018 оны 2 дугаар сард бүрэн оруулсан байна.

2019 онд Дундговь аймгийн Өлзийт, Сайнцагаан сумын газар зүйн нэрийн тодруулалтыг орон нутгийн төсвөөр гүйцэтгэж эхэлж байсан бол, 2019-2024 онд 17 аймгийн 117 сумын, нийслэлийн 5 дүүргийн газар зүйн нэрийн тодруулалтыг орон нутгийн төсвөөр хийхээр мөнгийг батлуулсан байна. Гэвч батлагдсан нэгдсэн арга зүйн баримт бичиг байхгүй.

2019 онд Барилга, байгууламжийн норм, нормчлолын сангийн хөрөнгөөр “Газар зүйн нэрийн тодруулалтын ажил” барилгын дүрмийг боловсруулж төслийг Барилга, хот байгуулалтын яамны /хуучин нэрээр/ Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд Засгийн газар журам болгон батлуулах нь зүйтэй гэж үзсэн. Харин Засгийн газар батлах хууль эрх зүйн орчин байхгүй тул батлагдаагүй байна.

2019 онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /хуучин нэрээр/-ын даргын А/211 дүгээр тушаалаар Газар зүйн нэрийн зөвлөлийг 19 байгууллагын 21 төлөөлөлтэй байгуулж 2024 он хүртэл жил бүр 4 удаа хуралдсан байна.

Геодези, зураг зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлд Уул, нуруу, тал, говь, цөл, мөрөн, гол, нуур зэрэг байгалийн объектын нэр; Улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр; Хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, усан сан, суваг, шуудууны нэр “Газар зүйн нэр”-нд хамаардаг.

Газар зүйн нэрийн асуудлыг 11 хуулиар /Монгол Улсын Үндсэн хууль, Монгол хэлний тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Газрын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хаягжуулалтын тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль/ зохицуулдаг бөгөөд Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 07 сарын 10-ны өдрийн 186 дугаар зарлиг, Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолоор Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт хамаарах 214805 газар зүйн нэрийг баталж, Газар зүйн нэрийг өөрчлөх тухай 2017 оны 20 дугаар тогтоолоор 1 нэрийг өөрчлөн баталж, MNS 6925-3:2021 стандартыг 2021 оны 07 дугаар сард батлуулан мөрдөж байна.

### **Газар зүйн нэрийн нөхцөл байдлын судалгаа**

*Хүснэгт 13*

Д/д	Хуулийн хэрэгжилтийн судалгаа	Тийм/үг үй	Тайлбар /зүйл, заалтын дугаар, хэрэгцээ, шаардлагыг энд бичих/
1	Геодези, зураг зүйн тухай хуулиар зохицуулсан зүйл, заалт, хэсэг		
1.1.	Нэр томъёоны тодорхойлолт хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /3 дугаар зүйл/	тийм	- 3.1.5 заалтыг хасах - “дэвсгэр нэр”-ийн талаар нэмэх

			\говийн аймгуудад толгойг “уул” гэж нэрлэх үзэгдэл ихээр гарч байна\
1.2.	Геодези, зураг зүйн үйл ажиллагаа хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /4 дүгээр зүйл/	Тийм	- 4.1.5 заалтыг сайжруулж засах - “газар зүйн нэрийг тодотгох, шинээр тогтоох, солбицолжуулах, нэрийн зураг үйлдэх, хувийн хэрэг хөтлөх, нэрийн мэдээллийн сан үүсгэх” нэмж тусгах
1.3.	Төрийн байгууллагын чиг үүрэгт тусгагдсан эсэх /5 дугаар зүйл/		5.1.3 5.2.3 Агентлагийн чиг үүрэгт байхгүй 5.8.2 5.8.4
1.4.	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний чиг үүрэгт тусгагдсан эсэх /6 дугаар зүйл/	байхгүй	
1.5.	Санхүүжилтийн асуудал тусгагдсан эсэх /7 дугаар зүйл/	байхгүй	Орон нутгийн төсвөөр хийх ажил
1.6.	ГЗЗ-н мэдээллийн улсын нэгдсэн санд хэрхэн шилжүүлэх, хадгалах, түгээх талаар тусгагдсан эсэх	тийм	Геодези, зураг зүйн тухай хууль: 9.2
		тийм	Газрын тухай хууль: 8.3.Аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийн, газар усны нэрийн болон газрын сангийн зургийг тухайн шатны Засаг дарга, улсын хэмжээний иж бүрэн хувийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус хадгална.
1.7.	Энэ асуудлаар хуулийн тусгайлсан зохицуулалт байгаа эсэх	тийм	11-р зүйл
1.8.	Хориглосон зохицуулалт хуулинд байгаа эсэх /12 дугаар зүйл/	тийм	Геодези, зураг зүйн тухай хууль: 12.1.3
			Газрын тухай хууль: 8.6.Албан ёсны баримт бичиг болон арга хэмжээнд газар усны давхар нэр хэрэглэх, газар усны албан ёсны нэрийг монгол хэлнээс бусад хэлээр орчуулах, бусад хэлний дуудлагаар галиглан бичихийг хориглоно.
2	Зөрчлийн тухай хуульд энэ асуудал тусгагдсан эсэх	тийм	11.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг
3	Энэхүү асуудлыг байнга, тодорхой хугацаанд шинэчлэх зохицуулалт бий эсэх	үгүй	УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолоор 4 жил тутам тодотгоно гэж тусгагдсан.
4	Энэхүү асуудлын тоо, хэмжээ		214805 нэр УИХ-аар батлагдсан
5	Улсын төсвөөр хийсэн ажлын мэдээ	үгүй	
6	Орон нутгийн төсвөөр хийсэн ажлын мэдээ	Тийм (2 тэрбум )	2019-2024 онд 17 аймгийн 117 сум, нийслэлийн 5 дүүрэгт газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийгдсэн.

7	Бусад байгууллагын /дотоодын болон гадаадын/ төсвөөр хийсэн ажлын мэдээ	үгүй	ШУА-ийн ГЗГЭХүрээлэн 2017 онд Газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлсэн боловч солбицлын тогтолцоог зөв оруулаагүйгээс байршлын хувьд алдаатай.
8	Үүнийг хэрэглэгчийн талаарх мэдээлэл	тийм	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага. Геопорталд дээрх алдаатай мэдээллийн санг оруулсан учир ашиглах боломжгүй.
9	Хэрхэн хэрэглээнд гаргаж байгаа талаарх мэдээлэл		Газар зүйн нэрийн зураг, газрын зураг, мэдээллийн сан, бусад баримтыг хүсэлтийн дагуу зөөврийн төхөөрөмж дээр хуулж өгдөг.
10	Хуулийн зохицуулалт шаардлагатай асуудлууд		<ul style="list-style-type: none"> <li>- газар зүйн нэрийн мэдээллийн сан, систем байгуулах. Газар зүйн нэрийн хувийн хэрэг бүрдүүлэх, хүсэлтийн маягт хүлээн авахад маш их хэмжээний цаас шаардагддаг. Иймээс мэдээллийн сан, систем бүрдүүлэх байгуулах шаардлагатай.</li> <li>- Газар зүйн нэрийн зураг, зохиох масштаб, нэрийн галиглал, орчуулга, газар зүйн нэрийг тодотгох хугацаа, хориглох асуудал</li> <li>- газар зүйн нэрийг тодотгох, шинээр тогтоох, солбицолжуулах, баталгаажуулах, газар зүйн нэрийн зураг зохиох журам</li> <li>- Газар зүйн нэрийн үндэсний зөвлөл, салбар зөвлөл</li> </ul>

Холбогдох хуулиудад газар зүйн нэр, томъёог дараах байдлаар зөрүүтэй бичсэн байна. Үүнд:

1/Геодези, зураг зүйн тухай, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд “**Газар зүйн нэр**”,

2/Газрын тухай, Зөрчлийн тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай, Хаягжуулалтын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулинд “**Газар үсны нэр**”,

3/Монгол хэлний тухай хуулинд “**Газар нутгийн нэр**”,

4/Эрүүгийн хуулинд “**Газар орны нэр**”.

#### **Үнэлгээ:**

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудад Газар зүйн нэр, томъёо зөрүүтэй байдлаар батлагдсан, газар зүйн нэрийг санаатай өөрчлөх, газар зүйн нэрийг Монгол хэлнээс өөр хэл дээр батлах, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөрчлөлтөөр газар зүйн нэрийн харьяалал өөрчлөгдөхөд Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулаагүй, газар зүйн нэрийн тодотголыг 1980 оноос хойш хийгээгүй байх бөгөөд газар зүйн нэр өгөх, өөрчлөх, тодотгол хийх, хамрах хүрээг тогтоох, солбицолжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх нэгдсэн арга зүй байхгүй байна.

Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд газар зүйн нэрийн чиглэлээр хийх ажлыг тодорхой тусгаагүй учраас геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцах чиг үүрэг тодорхойгүй байна.

Газар зүйн нэрийн асуудлыг 11 хууль, Ерөнхийлөгчийн 1 зарлиг, УИХ-ын 1 тогтоолд тусгасан боловч нэгдсэн нэр томъёог хэрэглээгүй, 2 хуульд 4 өөр нэр томъёог ашиглаж байна. 4 хуульд “газар зүйн нэр” гэсэн нэр томъёог ашиглаж байгаа бол бусад 7 хуульд өөр нэр томъёог ашигласан.

Газар зүйн нэрийг батлах, өөрчлөх, газар зүйн нэрийн зураг хадгалах, ашиглах асуудлыг Геодези, зураг зүйн тухай хууль болон Газрын тухай хуулиудад давхардуулан зохицуулсан.

1980-1985 онд газар зүйн нэрийг тодруулсан. УИХ-ын 2003 оны 42-р тогтоолоор газар зүйн нэрийн жагсаалтыг 4 жил тутам тодотгохоор заасан боловч 2019 оноос тодотгож эхэлсэн. Хэдэн жил тутам газар зүйн нэрийг тодотгох нь хуульд тусгагдаагүй.

### **3.6.Шалгуур үзүүлэлтийн томъёолол 6.Газрын зураг, түүний хэрэглээтэй холбоотой зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?**

Газрын зураг гэж дэлхийн гадаргуу, огторгуй ертөнцийн бусад бодит биет буюу тэдгээрийн хэсгийг хавтгайд тодорхой масштаб, тусгаг, таних тэмдэг ашиглан жижигрүүлэн буулгаж дүрсэлсэн зургууд юм.

Газрын зургийг агуулга, хэрэглээнээс хамааруулан дараах төрөлд хуваана. Үүнд:

1. байр зүйн зураг;
2. дэвсгэр зураг;
3. хаягийн зураг;
4. гүйцэтгэлийн зураг;
5. кадастрын зураг;
6. өндөржилт төлөвлөлтийн зураг;
7. газар зүйн нэрийн зураг;
8. ортофото зураг;
9. сэдэвчилсэн газрын зураг, атлас;
10. жижүүрлэлтийн газрын зураг;
11. бусад.

Газрын зургийн масштаб томрох тусам илүү их мэдээлэл агуулах боловч бага талбайг хамрах бөгөөд хэмжилтийн нарийвчлал сайжирдаг бол харин масштаб жижигрэх тусам том талбайг хамарч, нарийвчлал мууддаг. Масштабаас хамаарсан газрын зургийн хэрэглээнээс дурдвал:

-1:10000, 1:25000, 1:50000, 1:100000-ны масштабтай байр зүйн зургийг байгалийн нөөц, баялгийг ашиглан хамгаалах, төрөл бүрийн инженерийн барилга байгууламжийн хайгуул судалгаа хийх, улс ардын аж ахуйн бусад салбар болон батлан хамгаалах хэрэгцээний зориулалтаар улсын хэмжээний байр зүйн зураг зохиоход зориулан гүйцэтгэнэ.

-1:10000, 1:25000-ны масштабтай байрзүйн зураг нь, 1:50000, 1:100000-ны болон бусад жижиг масштабын байр зүйн зураг, сэдэвчилсэн зураг ба зураг зүйн бусад баримт бичиг зохиоход тулгуур материал болно.

-1:100-1:200-ны масштабтай байр зүйн зургийг доорх зориулалтаар хийнэ. Үүнд:

- инженерийн барилга байгууламжийн нарийвчилсан төлөвлөлт,
- газар доорх болон гүүрэн байгууламж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шугамын суурилуулалт

-1:500-ны масштабтай байр зүйн зургийг доорх зориулалтаар хийнэ. Үүнд:

- барилгажсан талбайн байр зүйн болон дэвсгэр зураг зохиох,
- инженерийн барилга байгууламжийн нарийвчилсан төлөвлөлт,

-1:1000-ны масштабтай байр зүйн зургийг доорх зориулалтаар хийнэ. Үүнд:

- төв суурин газрыг хаягжуулах,
- барилгажаагүй талбайн байр зүйн дэвсгэр зураг зохиох,
- инженерийн барилга байгууламжийн нарийвчилсан төлөвлөлт,
- хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны газар хөдлөлийн бичил мужлалын зураг зохиох,
- хот суурины хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт

-1:2000-ны масштабтай байр зүйн зургийг доорх зориулалтаар хийнэ. Үүнд:

- хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны газар хөдлөлийн бичил мужлалын зураг зохиох,
- хот суурины хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт,
- геологийн ерөнхий эрлийн нарийвчилсан судалгаа

-1:5000-ны масштабтай байр зүйн зургийг доорх зориулалтаар хийнэ. Үүнд:

- хот орчмын бүс болон орчны тойм зургийг зохиох,
- хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны газар хөдлөлийн бичил мужлалын зураг зохиох,
- газрын эвдрэлийн хэмжээг тодорхойлж, ажлын хэмжээ, зардлыг тооцох,

-1:10000-ны масштабтай байр зүйн зургийг доорх зориулалтаар хийнэ. Үүнд:

- Хөрсний нарийвчилсан зураг хийх ба хөрсний элэгдлийн эсрэг арга хэмжээ авах
- газар зохион байгуулах болон газар тариалангийн гол бүс нутгуудад газрын тооцоо, бүртгэл хийх,
- усжуулалтын барилга байгууламжийн төсөл зохиох,
- усжуулалтын ба газар хатаалтын ажлын хайгуул хийх, нарийвчилсан эрэл хайгуул,
- геологи ба геофизикийн зураглалын холболт хийх,
- нефть ба хийн хайгуулын орд газрын талбайн байрзүйн зураг зохиох, цооногийн байрлал, холболт хийх,
- усан цахилгаан станцын усан зангилгааг /гидроузел/ тогтоох,
- тэгш тал газарт усан сангийн төсөл зохиох,
- сувгийн хайгуул хийх,
- үерийн хамгаалалтын барилга байгууламж төлөвлөх,
- ажлын онцгой хүнд нөхцөлтэй газарт төмөр ба авто замын трассын хайгуул хийх, техникийн төсөл зохиох,
- яндант дамжуулга болон цахилгааны ба холбооны шугамын трассыг сонгох,
- цахилгааны дэд станцын байрлал түүнээс цахилгааны шугамын оролт гаралтын холболтын төлөвлөгөө зохиох,
- ой зохион байгуулалт,
- ойн усжуулалт ба мод тээвэрлэлтийн ажлыг зохион байгуулах,
- ойг нөхөн сэргээх ба мод үржүүлгийн талбайн төлөвлөлт хийх,
- хот, суурин газрын ерөнхий төлөвлөгөө зохиох;
- орон сууц, үйлдвэр инженерийн шугам сүлжээ, цэцэрлэг, гудамж талбайн байрлалын төсөл зохиох,
- инженер геологи ба гидрогеологийн хайгуул хийх.

-1:25000-ны масштабтай байр зүйн зургийг доорх зориулалтаар хийнэ. Үүнд:

- газар зүйн нэрийн зураг зохиох,
- Хөдөө аж ахуйн бүсчилсэн төлөвлөлтийн схем зохиох,
- хөдөө аж ахуйн газар зохион байгуулалт,
- хөрс хамгаалалтын арга хэмжээ авах,
- хөрсний ба геоботаникийн судалгаа ба зураглалд,
- газар хатаах, услуулах ажлын хэтийн төлөвлөлтийн төсөл зохиох,
- геологи хайгуулын эрэл ба эрэл-хайгуулын ажил явуулах,
- геофизикийн судалгаа,
- нефть ба хийн орд газрын барилга байгууламжийн урьдчилсан төсөл зохиох,
- гол, усан сувгийг ашиглах схемийн үндэслэл,

- гидроузел, усан сан /түүний хэмжээ живүүлэх талбайн хэмжээ/-ний байршлыг тогтоох,
- төмөр ба авто замын хайгуул хийж, трасс төлөвлөх;
- яндант дамжуулга, цахилгаан ба холбооны шугамын трассын хувилбаруудыг сонгох,
- ой зохион байгуулалт, ойн аж ахуйг байгуулах төсөл зохиох,
- суурин газрын тохижилтын ба барилгажилтын урьдчилсан төсөл зохиох;
- онцгой байдлын оператив /шуурхай/ ажиллагааны схем зохиох,
- хотын гаднах бүсийн тохижилтын төсөл зохиох.

-1:50000-ны масштабтай байр зүйн зургийг доорхи зориулалтаар хийнэ. Үүнд:

- Монгол орны геологийн зураглал
- ашигт малтмалын тархацыг зураглах
- ойн нөөц, томоохон хэмжээний төмөр ба авто замын трассын хайгуул хийж, төлөвлөх;
- цахилгаан ба холбооны шугамын трассын хувилбаруудыг сонгох
- онцгой байдлын оператив /шуурхай/ ажиллагааны схем зохиох

-1:100000-ны масштабтай байр зүйн зургийг дараах зориулалтаар хийнэ. Үүнд:

- газар нутгийг судлах,
- суурингаас бусад газрыг хаягжуулах,
- шинээр хот болон хурдны зам, төлөвлөлт, урьдчилсан зураг төсөл боловсруулах,
- ашигт малтмалын ордыг ашиглах,
- газрын эвдрэлийн хэмжээг тодорхойлж, ажлын хэмжээ, зардлыг тооцох,
- улсын эдийн засгийн ач холбогдолтой томоохон объект,
- газрын нөхөн сэргээлт,
- шинэ хөдөө аж ахуйн газрыг хөгжүүлэх,
- газар нутгийн ерөнхий геологийн зураглал,
- ойн аж ахуй, байгалийн нөөц, нөөцийг зохион байгуулах,
- цэргийн байгууламжийн зураг төсөл, барилга байгууламжийн практик асуудлыг шийдвэрлэх,
- байлдааны бэлтгэлийг хангах,
- байлдааны ажиллагааг төлөвлөх, явуулах, түүнчлэн үндэсний батлан хамгаалахын ашиг сонирхолд нийцсэн бусад ажлыг шийдвэрлэх

Дунд масштабын байр зүйн зураг нь байгаль орчин, хөдөө аж ахуй, батлан хамгаалах, хот, суурин, төмөр зам, авто зам, дэд бүтцийн шугам сүлжээ төлөвлөх, геологийн нарийвчилсан эрэл хайгуул хийх, газар тариалангийн кадастрын зураг зохиох зэрэг улс орны эдийн засгийн чухал салбаруудын суурь мэдээлэл болдог.

Мөн уг масштабын байр зүйн зургийг дэлхийн хөгжилтэй улс орнууд Үндэсний орон зайн мэдээллийн суурь өгөгдөл болгон ашиглаж байна.

Геодези, зураг зүйн тухай хуулиар нийтийн болон тусгай зориулалтын газрын зураг, бүтээгдэхүүнийг ялган тодорхойлоогүйгээс газрын зургийг нийтийн хэрэгцээнд гаргах, ашиглуулах, төрөөс цахим газрын зургийн үйлчилгээ үзүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

#### **Үнэлгээ:**

Хуульд нийтийн буюу иргэний, тусгай буюу батлан хамгаалах зориулалтын гэх мэтээр газрын зургийн хэрэглээг ангилж, геодези, зураг зүйн үйл ажиллагаанд хамаарах асуудлуудыг тодорхой тусгах шаардлагатай байна.

**3.7.Шалгуур үзүүлэлтийн томъёолол 7.Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сангийн зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?**

Хүчин төгөлдөр мөрдөж байгаа Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.7.2-т “улсын захиалга, даалгавраар болон салбарынхаа хүрээнд хийх геодези, зураг зүйн ажлын дараа жилийн захиалгыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор гаргаж өгөх” гэж, 5.7.3-т “өөрийн хэрэгжүүлж буй төслийн хөрөнгөөр хийгдэх геодези, зураг зүйн ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран сонгон шалгаруулалт (тендер)-ын журмаар явуулах” гэж заасан боловч этгээд заалтууд огт хэрэгжээгүй.

Өнгөрсөн 28 жилийн хугацаанд геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бусад салбараас нэг ч захиалга ирээгүй, мөн бусад салбарт хийсэн нэг ч геодези, зураг зүйн ажлын тендерийг хамтран зохион байгуулж шалгаруулсан тохиолдол байхгүй. Бусад салбарууд өөр ажлын нэрэн дор геодези, зураг зүйн ажлыг оруулж далд хэлбэрээр гүйцэтгүүлдэг байдал бий болсон Тухайлбал: “авто замын зураг төсөл боловсруулах”, “төмөр замын зураг төсөл боловсруулах”, “усны барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах”, “хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зураг зөсөл боловсруулах” г.м-ээр тендер зарлаж өөрсдөө шалгаруулдаг хэдий ч энэ бүх ажил дотор хамгийн их зардал гардаг байр зүйн болон дэвсгэр зураг заавал хийдэг, энэ ажлын үр дүнгээ геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлдэггүй эсвэл шаардуулж байж хагас дутуу ирүүлдэг жишиг тогтсон.

Үүнээс шалтгаалж энэ олон жилд бусад салбарт хийсэн геодези, зураг зүйн ажлын үр дүн геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн санд гүйцэд төвлөрдөггүй, нэг ажлыг давтан хийж, үргүй зардал гаргадаг байдал үргэлжилсээр байна.

Геодези, зураг зүйн /ГЗЗ/ мэдээллийн нэгдсэн санд хадгалагдаж байгаа ихэнх баримт материал (хэвлэмэл газрын зураг, альбом, тайлан, агаар, сансрын зургийн хальс г.м) цаасан буюу аналог хэлбэртэй байгаа бөгөөд хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэхэд мэдээлэл хайж цаг алдах, нэг төрлийн мэдээллүүд хоорондоо зөрөөтэй байх, хуучирч үрэгдэх г.м хүндрэл үүсч байна.

Түүхэн газрын зураг материалыг цахим хэлбэрт шилжүүлснээр одоогийн байдлыг харуулсан цахим зурагтай давхцуулан харах, өөрчлөлтийн дүн шинжилгээ хийх, ирээдүйн төлөвлөлтийг оновчтой хийх боломж бүрддэг чухал ач холбогдолтой.

Хуулийн зохицуулалтгүйгээс бусад салбарт хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажлын үр дүн ГЗЗ мэдээлийн нэгдсэн санд төвлөрдөггүй, уг үр дүнд чанар, нарийвчлалын шаардлага хангасан эсэхэд дүгнэлт хийх боломжгүй, салбартаа хийгдэх геодезийн ажлыг төлөвлөхдөө ГЗЗ мэдээллийн нэгдсэн сангаас мэдээлэл, лавлагаа авдаггүй зэргээс шалтгаалж нэг ажлыг хэд хэдэн удаа өөр өөр байгууллагад давтан хийж, үргүй зардал гаргадаг.

Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйл ажиллагааны үр дүнд бий болсон төрөл бүрийн газрын зураг, тоон мэдээлэл нь олон зорилго, зориулалтаар ашиглаж болох бусад салбарын суурь ажил, үйлчилгээ байдаг бөгөөд тэдгээрийг нэгдсэн нэг санд (төрийн архив)-д архивлахаар Геодези, зураг зүйн тухай хуульд тусгасан байдаг боловч хэрэгждэггүй. Геодези, зураг зүйн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг төлөвлөх, захиалах, төсөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний дараалал, хэрэгжүүлэх субъект зэрэг асуудлууд хуулинд тодорхойгүй байна.

Бусад салбаруудад улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улс, олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийгдэж бий болсон агаар, сансрын зураг, газрын зураг, тоон мэдээлэл нь геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд нэгтгэгдээгүй, мэдээллийн сан нэгдмэл бус байна.

Салбар бүрт геодези, зураг зүйн ажил давхардаж хийгдэх, давхардсан хөрөнгө оруулах зэрэг асуудлууд гарсаар байна. Тухайлбал, нутаг дэвсгэрийг бүхэлд нь бүрхсэн 1:100000-ны масштабтай байр зүйн зургийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагаас тоон хэлбэрт оруулсан байхад Геологийн төв лаборатори, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд тус тусдаа тоон хэлбэрт оруулж өөрийн үйл ажиллагаандаа ашигласан. Өөрөөр хэлбэл 1:100000-ны масштабтай байр зүйн зургийг тоон хэлбэрт оруулахад улсын төсвөөс 3 удаа зардал гаргасан байна.

Газрын харилцаа, байгаль орчин, геологи, уул уурхайн салбар болон нийслэл хотод 1990-ээд оноос хэрэгжүүлсэн улсын болон орон нутгийн төсөв, гадаад, дотоод төсөл хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэсэн газрын зураг, тоон мэдээлэлд тулгуурлан газар зүйн мэдээллийн системийг байгуулан ашиглаж эхэлсэн боловч үүсгэсэн мэдээллийн сангууд нь геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд холбогдоогүй, мэдээлэл солилцох нөхцөл бүрдүүлээгүй, нэгдсэн стандартгүйгээс мэдээллүүдийг давхцуулан ашиглах боломжгүй, ижил төрлийн ажил давхардан хийгдсэн зэрэг асуудлууд бий болсон байна.

### **Үнэлгээ:**

Геодези, зураг зүйн бүтээгдэхүүнийг цаасан буюу аналог хэлбэрээр зохиож хэрэглэдэг байдал техник, технологи хөгжсөн өнөөд үед өөрчлөгдөж, цахим хэлбэрээр хэрэглэх нь түгээмэл болж байгаа ч урьд цуглуулсан сан хөмрөгийг цахимжуулах шаардлагатай байна.

Геодези, зураг зүйн мэдээлэл, бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн удирдлага-мэдээллийн цахим систем, дэд сангууд, үйлчилгээ үзүүлэх цахим платформ байгуулж, ажил төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнг хүлээн авах, хяналт тавих, хэрэглэгчдэд үйлчлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон геодези, зураг зүйн ажил, үйлчилгээ захиалагч байгууллагуудын эрх үүргийг тодорхойлсон тусгайлсан зохицуулалтыг хуульд шинээр нэмж оруулах зайлшгүй шаардлагатай байна.

Мөн ГЗЗ-н мэдээллийн нэгдсэн санд хадгалагдаж байгаа мэдээлэл нь орон зайн өгөгдөл, мэдээллийн суурь болдог тул орон зайн өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэгч бусад төрийн байгууллагуудын уг системд/санд хандан хэрэгцээтэй мэдээллээ авах эрх, өөрсдийн хариуцан бүрдүүлэх мэдээллээ тогтоосон хугацаанд, чанар, нарийвчлалын шаардлага хангасан өгөгдөл, мэдээллийг уг санд оруулж байх үүргийг хуулийн холбогдох хэсгүүдэд шинээр томъёолж оруулах шаардлагатай.

Геодези, газрын зураг, орон зайн өгөгдлийг нэгдсэн стандартаар бий болгох, байгууллага хооронд тэдгээрийг төрийн нэгдсэн сүлжээгээр (портал) дамжуулах, бүртгэлжүүлэх, төрийн байгууллагууд хоорондын ажлын уялдааг хангах, төрөөс иргэн, хуулийн этгээдэд газрын зураг, тоон мэдээллээр хангах, мэдээллийн үнэн, зөв байдал, мэдээллийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, мэдээллийг шинэчлэх, мета өгөгдөл, нэгдсэн стандартад оруулах, үйл ажиллагааны нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх зэрэг асуудлуудыг хуульд тусгах шаардлагатай байна.


### **3.8.Шалгуур үзүүлэлтийн томъёолол 8.Улсын хилийн шугам болон засаг захиргааны хилийн эргэлтийн цэг, бүх төрлийн кадастрын зураглалын эргэлтийн цэгийг тогтоох зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?**

Улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг анх 1959 оны аж ахуй хоорондын газар зохион байгуулалтын ажлаар тогтоож Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1960 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 142 дугаар зарлигаар баталсан. Улмаар 1977 онд улсын хэмжээнд нийт аймаг, сумдын хилийн цэсийг газар дээр нь шинэчлэн тодотгосон материалыг үндэслэн Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн 75 дугаар зарлигаар дахин засаг захиргааны нэгжийн хилийн цэсийг шинэчлэн баталсан.

Үүнээс хойш улсын хэмжээнд шинээр сум нэмж байгуулах, татан буулгах зэрэг засаг захиргааны нэгжийн хилийн цэсийн өөрчлөлтүүдийг тухай бүрд нь Ардын Их Хурлын

Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолоор баталсан бөгөөд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг 13 удаа, Улсын их хурлын тогтоол 15 удаа гарсан байна.

2012 оноос 2015 оны хооронд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолын дагуу М1:100000-ны масштабтай байр зүйн зурагт суурилан солбицолжуулсан бөгөөд тус хилийн цэсийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд, бусад салбарууд өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.



*Зураг 40. М1:100000-ны масштабтай байр зүйн зурагт суурилан солбицолжуулсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн зураг*

Газрын маргаан бүх нийслэл, аймаг, сумын хэмжээнд байнга гардаг бөгөөд үүнтэй холбоотойгоор иргэний эзэмших, өмчлөх эрх ноцтойгоор зөрчигддөг. Мөн бэлчээрийн, өвөлжөө, хаваржаа, зуслангийн, нутаг дэвсгэрийн маргаан тасардаггүй.

#### **Үнэлгээ:**

Бүх төрлийн эргэлтийн цэгийг өндөр нарийвчлалтайгаар геодезийн хэмжилтийн аргаар тодорхойлох бодит шаардлагатай бөгөөд солбилцолоор эргэлтийн цэгүүдийг баталгаажуулдаг шинэлэг систем бий болгох шаардлагатай байна.

Ингэснээр иргэн, аж ахуйн нэгжийн газрын маргаанаас авахуулаад цаашлаад аймаг сумдын хилийн цэсийн маргаанд цэг тавих болно.

#### **3.9. Шалгуур үзүүлэлтийн томъёолол 9. Геодезийн хэмжилт, зураглалын ажилд хяналт тавих зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжиж байгаа эсэх?**

Геодзи, зураг зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлд Геодези, зураг зүйн улсын хяналтын асуудлыг зохицуулсан бөгөөд геодези, зураг зүйн улсын хяналт нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэний геодези, зураг зүйн талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, дүрмийн биелэлтийг хангахаар тусгасан байдаг.

Геодези, зураг зүйн улсын хяналтыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

Түүнчлэн геодези, зураг зүйн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батлахаар заасан байдаг боловч өнөөдрийг хүртэл батлагдаагүй. .

Геодези, зураг зүйн үйл ажиллагаа нь хээрийн хэмжилт болон суурин боловсруулалт гэсэн хоёр хэсгээс бүрддэг тул түүнд тавих хяналт нь мөн хээрийн болон суурин бүрдэлтэй байж, геодези, зураг зүйн ажлын хяналтыг магадлал, магадлан хэмжилт болон захиалагчийн техникийн хяналт гэсэн хэлбэрээр хийх нь оновчтой.

Магадлалыг геодези, зураг зүйн ТЭЗҮ, техникийн төсөл, ажлын даалгавар, атлас, альбом зэрэг суурин аргаар гүйцэтгэсэн бичиг баримт, бүтээлд, магадлан хэмжилт болон захиалагчийн техникийн хяналтыг геодезийн төрөл бүрийн сүлжээний хэмжилт, боловсруулалт, төрөл бүрийн масштабын байр зүйн болон дэвсгэр зураг, агаарын сансрын зураглал зэрэг зайлшгүй хээр явж, газар дээр нь хэмжиж шалгах шаардлагатай үйл ажиллагаануудад хийнэ.

Өөрөөр хэлбэл, магадал хийх ажил нь суурин аргаар богино хугацаанд бага нөөцөөр хийх боломжтой байхад магадлан хэмжилт болон захиалагчийн техникийн хяналт хийх ажил нь зардал, цаг хугацаа, хүн хүч, техникийн нөөц шаардсан ажил болдог.

Магадлал, магадлан хэмжилт болон захиалагчийн техникийн хяналтыг салгаж, ямар хэмжээний ажилд магадлан хэмжилт буюу хээрийн хяналт шалгалтыг хийх, зардлыг хаана тусгах, захиалагч ба гүйцэтгэгч нь хэн байх, үр дүнг хэрхэн баталгаажуулах асуудлыг хуульд тусгаж шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

#### **Үнэлгээ:**

Геодези, зураг зүйн тухай хуульд геодези, зураг зүйн ажлын хяналт хийх зохицуулалтыг нарийвчлан тусгаагүйгээс эрх бүхий байгууллагад ажиллаж байгаа хяналтын байцаагчдын орон тоо хүрэлцээгүй, салбар бүр өөрийнхөө салбарт хийж байгаа геодезийн хэмжилт зураглалын ажлыг өөрсдөө зохион байгуулдаг, ажлын үр дүнд хяналт тавьдаггүй, өгөгдөл, мэдээллийг Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд төвлөрүүлдэггүй асуудал түгээмэл байна.

Үүнээс шалтгаалж нэг ажлыг давтан хийж улсын төсвийг үр ашиггүй зарцуулдаг, чанарын шаардлага хангаагүй ажлын үр дүн хүлээн авснаас ирээдүйд хэрэглэгчдэд хүндрэл учрах, төсөл тооцоо буруу болох, цаг хугацаа алдах зэрэг дам хохирол үүсч байна.

Мөн геодези, зураг зүйн ажилд магадал хийх хүрээ, хэмжээ болон магадал хийх хүний нөөц, тэдгээрийн чадавхид тавих шалгуурыг тодорхойлох зайлшгүй нөхцөл үүсч байна.

Дээрх шалтгаануудын улмаас геодези, зураг зүйн ажлын хяналтын асуудлыг хуульд нарийвчлан зохицуулах шаардлага урган гарч байна.

Түүнчлэн геодези, зураг зүйн хяналт хийх эрх бүхий төрийн байгууллага уг хяналтыг салбарын төрийн бус байгууллагатай хамтран хүн хүчний болон тоног төхөөрөмжийн нөөцөд тулгуурлан хийх зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай.


### **3.10.Шалгуур үзүүлэлтийн томьёолол 10.Хуулиар зохицуулагдаагүй харилцаа байгаа эсэх?**

Монгол Улсад агаарын зураглалын ажлыг анх 1944-1949 оны үед ЗХУ-ын Батлан хамгаалах яамны Цэргийн байр зүйн албанаас Монгол орны нутаг дэвсгэрийг 1:100000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах зорилгоор 1:40000-1:60000-ны нислэгийн масштабтай агаарын зургийг ЗХУ-ын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар авч байсан.


1960 оны үеэс агаарын зураглалын ажил дахин сэргэж ЗХУ-ын Геодези, зураг зүйн ерөнхий газраас Монгол орны нутаг дэвсгэрийг дунд масштабын байр зүйн зургаар зурагжуулах зорилгоор 1:32000, 1:45000-ны нислэгийн масштабын агаарын зураглалын ажлыг эрчимтэй гүйцэтгэж байсан.

1980 онд Улсын геодези, зураг зүйн газар (хуучнаар) нь агаарын зураглалын Ан-30 онгоцыг тоног төхөөрөмжийн хамт худалдан авч үндэсний мэргэжилтнүүдийн хүчээр агаарын зураглал хийх, боловсруулах ажлыг гүйцэтгэх болсон ба дээрх ажлын үр дүнд Монгол орны нутаг дэвсгэрийг бүхэлд нь 1:100 000-ны масштабтай байр зүйн зургаар, нутаг дэвсгэрийн 30 гаруй хувийг 1:25 000-ны масштабын, 21.9 хувийг 1:50 000-ны масштабын байр зүйн зургаар тус тус зурагжуулсан юм.

Монгол Улсын Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон БНХАУ-ын Байгалийн нөөцийн яамны газрын хиймэл дагуулын алсын зайнаас тандан судлах төв хооронд хиймэл дагуулын өгөдлийн хэрэглээ, мэдээлэл харилцан солилцох санамж бичгийн хүрээнд ЗҮ-3 хиймэл дагуулын сансрын зургийг 2018-2023 оны хооронд нийт нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан 2,1 метрийн нарийвчлалтай сансарын зураг хадгалагдаж байна.



Зураг 38. 1:60 000-ны масштабтай агаарын зураг /1944-1949/




Зураг 39. 1:45 000-ны масштабтай агаарын зураг /1944-1949/

Гэвч агаар сансраас зураг авах, геодези, зураг зүйн үйл ажиллагаанд сансрын технологи, хиймэл дагуулын станц ашиглах, дроны нислэг, ортофото зураг үйлдэх, агаар сансрын зургийн боловсруулалт, тоон мэдээлэл гарган авах харилцааг хуулиар зохицуулаагүй байна.

Мөн томоохон хот, суурин, аймаг, сумын төв, уурхай дэд бүтцийн ажил хийгдэж байгаа газруудад тодорхой интервалтайгаар ортофото зураг авч эдийн засгийн эргэлтэд оруулах, цаашлаад түүхэн баримт болгон үлдээх нийгмийн зайлшгүй шаардлагатай.

Монгол-ОХУ-ын хил шалгалтын ажилд зориулж, GNSS-ын 178 цэгтэй А,В,С ангийн сүлжээг 2023 онд улсын хойд хилийн шугамын дагуу болон түүний ойр орчимд байгуулсан. Уг сүлжээний цэгийн байрлалыг 14-р зурагт үзүүлэв.



14-р Зураг. 2023 онд байгуулсан GNSS-ын сүлжээний бүдүүвч

#### GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станц

**Уг станц нь өөрийн байрлалаа дэлхийн төвтэй харьцангуйгаар, өндөр нарийвчлалтай, тасралтгүй тодорхойлж байдаг.**

GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станц байгуулах ажлууд шат дараалан хийгджээ. Үүнд:

- 2000 онд УГЗЗГ /хуучнаар/ анхны байнгын ажиллагаатай Javad фирмийн GPS-ийн хүлээн авагч, антен бүхий станцыг байгуулсан. Швед улсын мэргэжилтнүүд станцын хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлж, уг станцыг ажиллуулах 2 мэргэжилтнийг Швед улсад дадлагажуулан сургажээ.

- 2005 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Швейцар улсын Leica фирмийн GPS-ийн байнгын ажиллагаатай 2 станц, Leica фирмийн тусламжаар 1 станц нийт 3 станцыг Улаанбаатар хотын Амгалан өртөө, Иргэний нисэх ерөнхий газрын харьяа байгууламж дээр болон ГХГЗЗГ-т тус тус суурилуулж, 2 мэргэжилтнийг Швейцар улсад сургалтад хамруулсан.

- 2010 онд Монголын мянганы сорилтын сангийн /МСС/ “Хөрөнгийн эрхийн бүртгэл” төслийн шугамаар Улаанбаатарт 4ш, Дарханд 1ш, Эрдэнэтэд 1ш нийт 6ш АНУ-ын Trimble


фирмийн станцыг газрын кадастрын зураглалын ажилд ашиглахаар суурилуулж, 2 мэргэжилтнийг АНУ-д сургалтад хамруулжээ.

●2011 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс, Архангай аймгуудад Trimble фирмийн 2 станц, Булган аймагт ГХБГЗЗГ-т ашиглаж байсан хуучин Leica фирмийн 1 станцыг шилжүүлэн тус тус суурилуулсан. GNSS-ын байнгын ажиллагаатай станцуудыг интернетийн нэгдсэн сүлжээнд холбож, онлайн байдлаар хэрэглэгчдэд станцуудын 24 цагийн статик өгөгдлийг түгээж эхэлсэн ба ГХБГЗЗГ-т сервер байрлуулсан. Trimble Dynamic Control програм хангамж нийлүүлж МСС-ын хүрээнд суурилуулсан 6 станцыг холбосон. Ингэснээр Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Улаангом, Цэцэрлэг хотуудад интернетийн сүлжээ ашиглан станцуудын RTK засварыг дамжуулж эхэлсэн ба хэрэглэгчид үүрэн холбооны сүлжээгээр мэдээлэл дамжуулах GPRS технологийг ашиглан RTK хэмжилт хийх боломж бүрдсэн.

●2012 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Завхан, Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь аймгуудад GNSS-ын байнгын ажиллагаатай 8 станц суурилуулсан.

●2013-2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 23 станц шинээр байгуулсан ба барилга дээр суурилуулсан зарим станцуудыг газарт шилжүүлсэн байна.

●2017 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотод шинээр 5 станцыг суурилуулсан.



15-р Зураг. БАСС-ын байрлалын бүдүүвч

Шинжлэх ухаан техник, технологийн дэвшил, дэлхийг тойрон нисэх хиймэл дагуулыг зохион бүтээсэн цагаас эхлэн геодезийн сүлжээг байгуулах арга технологид шинэ дэвшил гарч, олон улсад 1980-аад оноос эхлэн GNSS-ын технологи ашиглан байрлал, өндрийг хамт хэмжиж 3 хэмжээст сүлжээг байгуулдаг болсон.

Энэ технологи Монгол Улсад 1990-ээд оноос нэвтэрч, анх 1997 онд геодезийн сүлжээг GNSS-ын технологи ашиглан шинэчлэн байгуулсан түүхтэй.

Геодезийн сүлжээ гэсэн ойлголтод уламжлалт сүлжээ болох байрлал, өндөр, гравиметрийн сүлжээ багтдаг бөгөөд орчин үед навигацийн хиймэл дагуулын технологид суурилсан GNSS-ын 3 хэмжээст сүлжээг нэмж хамааруулдаг болсон.

Харин 1997 онд батлагдсан Геодези, зураг зүйн тухай хуульд хиймэл дагуулын технологид суурилсан GNSS-ын сүлжээ байгуулах асуудал огт тусгагдаагүй. Энэ шинэ технологийг геодезийн үйлдвэрлэлд ашиглах хуулийн зохицуулалтгүйгээр өнөөг хүрсэн боловч 1990-ээд оноос эхлэн манай улсад GNSS-ын технологийг геодезийн сүлжээ байгуулах, геодезийн төрөл бүрийн хэмжилт зураглал үйлдэхэд өргөн ашиглаж, хөгжүүлсээр ирлээ.

Өнөөдрийн байдлаар ГЗБГЗЗГазар, ШУА, Нийслэлийн харьяалалын нийт 60 гаруй байнгын ажиллагаатай станц ажиллаж байна. Мөн уул уурхайн томоохон аж ахуйн нэгжүүд өөрсдийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор байнгын ажиллагаатай станцуудыг суурилуулсан байдаг. Эдгээр станцууд орчин үеийн геодезийн 3 хэмжээст тулгуур сүлжээг бүрдүүлж байна.

**GNSS-ын сүлжээ, GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станц нөхцөл байдлын судалгаа**

Хүснэгт 11

д/д	Хуулийн хэрэгжилтийн судалгаа	Тийм/ үгүй	Тайлбар /зүйл, заалтын дугаар, хэрэгцээ, шаардлагыг энд бичих/
1	Геодези, зураг зүйн тухай хуулиар зохицуулсан зүйл, заалт, хэсэг	үгүй	GNSS нь орчин үед геодезийн сүлжээ байгуулах үндсэн технологи болсон тул байрлалын сүлжээг GNSS-ын технологи ашиглан байгуулах, БАСС буюу идэвхтэй сүлжээ байгуулах талаар хуулийн холбогдох хэсэг бүрт шинэ зүйл заалт нэмж оруулах шаардлагатай.
1.1	Нэр томъёоны тодорхойлолт хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /3 дугаар зүйл/	үгүй	Байрлалын сүлжээ, GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станц гэсэн нэр томъёог хуульд шинээр оруулах
1.2	Геодези, зураг зүйн үйл ажиллагаа хэсэгт энэ асуудал тусгагдсан эсэх /4 дүгээр зүйл/	үгүй	Байрлалын сүлжээ байгуулах, GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станц байгуулж ажиллуулах гэсэн үйл ажиллагааг хуульд шинээр оруулах
1.3	Төрийн байгууллагын чиг үүрэгт тусгагдсан эсэх /5 дугаар зүйл/	үгүй	Улсын геодезийн тулгуур сүлжээ болж байгаа GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станц байгуулах ажлыг зохион байгуулах, хянах, хэвийн ажиллагааг хангах, эзэмших, үйл ажиллаганы зардлыг жил бүр улсын төсөвт тусгуулж байх асуудлыг хариуцсан төрийн байгууллагын чиг үүрэгт тусгаж оруулах. Энэ нь ашгийн бус бөгөөд зөвхөн төр хариуцан төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэх улс орны онцгой дэд бүтэц юм. GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станцын хамгаалалтын зурвасыг тогтоох зохицуулалтыг оруулах.
1.4	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний чиг үүрэгт тусгагдсан эсэх /6 дугаар зүйл/	үгүй	Байрлалын сүлжээний хэмжилт гүйцэтгэх, GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станц байгуулах ажлыг гүйцэтгэж болохоор хуульд тусгах
1.5	Санхүүжилтийн асуудал тусгагдсан эсэх /7 дугаар зүйл/	үгүй	Энэ ажил нь ашгийн бус бөгөөд улс орны онцгой дэд бүтэц тул зөвхөн улсын төсвөөс санхүүжүүлэхээр хуульд тусгах шаардлагатай.
1.6	ГЗЗ-н мэдээллийн улсын нэгдсэн санд хэрхэн шилжүүлэх,	үгүй	Байрлалын сүлжээний GNSS-ын хэмжилтийн анхдагч өгөгдөл, тэгшитгэн

	хадгалах, түгээх талаар тусгагдсан эсэх		бодолтын үр дүнг энэ санд оруулж байхаар хуульд тусгах.
1.7	Энэ асуудлаар хуулийн тусгайлсан зохицуулалт байгаа эсэх	үгүй	
1.8	Хориглосон зохицуулалт хуулинд байгаа эсэх /12 дугаар зүйл/	үгүй	
2	Зөрчлийн тухай хуульд энэ асуудал тусгагдсан эсэх	үгүй	
3	Энэхүү асуудлыг байнга, тодорхой хугацаанд шинэчлэх зохицуулалт бий эсэх	үгүй	Монгол Улсын геодезийн байрлалын сүлжээг 6-8 жил тутамд, хүчтэй газар хөдлөлт болсон тохиолдолд тухай бүр давтан хэмжиж шинэчилнэ
4	Энэхүү асуудлын тоо, хэмжээ		75 орчим станц үйл ажиллаж байна.
5	Улсын төсвөөр хийсэн ажлын мэдээ		ГЗБГЗЗЕГ 2010-2024онд улсын төсвийн хөрөнгөөр 43 станцыг 21 аймгийн төв, сум суурин газарт суурилуулсан
6	Орон нутгийн төсвөөр хийсэн ажлын мэдээ		ГЗБГЗЗЕГ 2017 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр УБ хот орчимд 5 станц суурилуулсан
7	Бусад байгууллагын /дотоодын болон гадаадын/ төсвөөр хийсэн ажлын мэдээ		Уул уурхайн ашигт малтмал чиглэлээр – 4, ШУ-ны судалгааны чиглэлээр ООГфХ – 16, Геодези, зураг зүйн үйлдвэрлэл эрхлэгч компани ААН- 6
8	Үүнийг хэрэглэгчийн талаарх мэдээлэл		Монгол Улсад Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж- (200 гаруй компани)
9	Хэрхэн хэрэглээнд гаргаж байгаа талаарх мэдээлэл		<a href="https://monpos.gazar.gov.mn/">https://monpos.gazar.gov.mn/</a> цахим системээр дамжуулан өгөгдлийг тэгшитгэн бодож байна. ГЗБГЗЗЕГ-ын виртуал сервер (66.181.168.80)-ээс хэрэглэгчдэд байршил тодорхойлох хиймэл дагуулын бодит агшны засвар (RTK) дамжуулалтыг түгээж байна.

Геодези, зураг зүйн үйл ажиллагааг зохицуулах норм, нормативын баримт бичгийн тогтолцоо тодохойгүй, хуулиар зохицуулагдаагүй байна.

Норм, нормативын баримт бичгийг боловсруулах, шинэчлэх ажлыг Барилгын норм, нормативын сангийн хөрөнгөөр боловсруулдаг байсан бөгөөд ийнхүү батлуулахад салбарын асуудал биш, санхүүжүүлэх эрх зүйн үндэслэл байхгүй зэрэг шалтгаанаар тус салбарын норм, дүрмийг шинэчлэхэд хүндрэл учирч байна. Мөн салбарын төрийн захиргааны төв байгууллага ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэнээр зохицуулалтгүй болсон байна.

#### **Геодези, зураг зүйн тухай хуулийг бүтцийн хувьд зарим улсын хуультай харьцуулсан байдал**

*Хүснэгт 12*

<b>МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ</b>	<b>ОХУ-ЫН ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙ БОЛОН ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ТУХАЙ</b>	<b>БНХАУ-ЫН ХЭМЖИЛ, ЗУРАГЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ</b>	<b>ЯПОН УЛСЫН ХЭМЖЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</b>
---	--	--	--

<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл</b>	<b>БҮЛЭГ 1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ</b>	<b>Бүлэг I. Ерөнхий зүйл 7 зүйлтэй, 12 заалттай</b>	<b>Бүлэг 1 Ерөнхий зүйл</b>
1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	Зүйл 1. Холбооны улсын энэ хуулийн үйлчлэх хүрээ		Зүйл 1 Зорилго, нэр томъёоны тодорхойлолт
2 дугаар зүйл. Геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж	Зүйл 2. Геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд үүсэх харилцааны эрх зүйн зохицуулалт		
3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо	Зүйл 3. Үндсэн ойлголт (хуулийн нэр томъёо)		
	Зүйл 4. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны субъект		
			Зүйл 2 Хэмжлийн стандарт
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ Геодези, зураг зүйн үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх байгууллага, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүрэг</b>			
4 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагаа	Зүйл 5. Геодези, зураг зүйн ажил		
	Зүйл 6. ОХУ-ыг батлан хамгаалах зорилгоор хийгдэх геодези, зураг зүйн ажил		
	<b>БҮЛЭГ 2. ОХУ-д ГЕОДЕЗИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦЛИЙГ ХАНГАХ</b>		
	Зүйл 7. Солбицлын тогтолцоо, улсын өндрийн тогтолцоо ба улсын гравиметрийн тогтолцоо	<b>Бүлэг II. Хэмжил, зураглалын эхлэл цэг, тогтолцоо</b>	
	Зүйл 8. Улсын геодезийн сүлжээ, улсын өндрийн сүлжээ ба улсын гравиметрийн сүлжээ	<b>Бүлэг III. Суурь хэмжил, зураглал</b>	<b>Бүлэг 2 Суурь хэмжил Зүйл 1 Төлөвлөлт, гүйцэтгэл Зүйл 2 Хэмжлийн үр дүн</b>
	Зүйл 9. Тусгай зориулалтын геодезийн сүлжээ	<b>Бүлэг IV. Хилийн хэмжил, зураглал ба бусад хэмжил, зураглал</b>	<b>Бүлэг 3 Нийтийн хэмжил Зүйл 1 Төлөвлөлт, гүйцэтгэл Зүйл 2 Хэмжлийн үр дүн</b>
			<b>Бүлэг 4 Суурь болон Нийтийн хэмжлээс бусад хэмжил</b>
5 дугаар зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг			

6 дугаар зүйл. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үүрэг	Зүйл 21. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл	Бүлэг V Хэмжил, зураглалын мэргэшилд тавигдах шаардлага	Бүлэг 5 Хэмжигч, туслах хэмжигч  Бүлэг 6 Хэмжлийн компаниуд Зүйл 1 Бүртгэл Зүйл 2 Хэмжлийн үйл ажиллагаа
7 дугаар зүйл. Санхүүжилт			
8 дугаар зүйл. Геодези, зураг зүйн улсын хяналт	Зүйл 22. Геодези, зураг зүйн салбар дах холбооны улсын хяналт		Зүйл 3 Хяналт, шалгалт Зүйл 4 Бусад
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ Бусад зүйл</b>	<b>БҮЛЭГ 3. ХОЛБООНЫ УЛСЫН ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ФОНД</b>	Бүлэг VI Хэмжил, зураглалын үр дүн	
9 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан	Зүйл 10. Холбооны улсын орон зайн өгөгдлийн фондыг бүрдүүлэх төрөл ба онцлог		
	Зүйл 11. Холбооны улсын орон зайн өгөгдлийн фонд		
	Зүйл 12. Холбооны улсын орон зайн өгөгдлийн фонд		
	Зүйл 13. Батлан хамгаалахын орон зайн өгөгдлийн фонд		
	Зүйл 14. Орон зайн өгөгдөл (орон зайн мета өгөгдөл)-ийн тухай мэдээ мэдээлэл		
	Зүйл 15. Зураглалын ажлын үр дүнд бий болгосон материал		
	Зүйл 16. Улсын чанартай байр зүйн зураг ба план зураг		
	Зүйл 17. Тусгай зориулалтын газрын зураг		
	<b>БҮЛЭГ 4. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АЖЛЫН МЭДЭЭЛЛИЙН ХАНГАМЖ</b>		
	Зүйл 18. Солбицлыг нь ашиглан олгох, ашиглуулах боломжтой мэдээлэл		
	Зүйл 19. Холбооны улсын ба бүс нутгийн орон зайн өгөгдлийн портал		
	Зүйл 20. Тоон зураглалын нэгдсэн суурь		
	<b>БҮЛЭГ 5. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ</b>		

	АЖИЛЛАГААНЫ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ		
	Зүйл 23. Зураглалын үйл ажиллагаа эрхлэх онцлог		
	Зүйл 24. Геодези, зураг зүйн ажилд тавих хязгаарлалт		
10 дугаар зүйл. Геодезийн байнгын цэг, тэмдэгт	3.8.12-3.8.17	Бүлэг VII Геодезийн цэг, тэмдэгтийг хамгаалах	
11 дүгээр зүйл. Газар зүйн нэр	Тусдаа хуультай		
12 дугаар зүйл. Хориглох үйл ажиллагаа			
13 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлөх			
14 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага		Бүлэг VIII Хуулийн хариуцлага	Бүлэг 8 Хуулийн хариуцлага
	БҮЛЭГ 6. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД Зүйл 25. "Газар нутгийн нэрийн тухай" Холбооны хуульд өөрчлөлт оруулах тухай Зүйл 27. ОХУ-ын Иргэний хуулийн дөрөвдүгээр хэсэгт өөрчлөлт оруулах тухай Зүйл 28. 2016 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 361-ФЗ тоот Холбооны хуулийг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр тасалбар болгон хүчингүй болсонд тооцсугай. Зүйл 29. "Төрөл бүрийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" Холбооны хуульд өөрчлөлт оруулах тухай Зүйл 30. "Үл хөдлөх хөрөнгийн төрийн бүртгэлийн тухай" Холбооны хуульд өөрчлөлт оруулах тухай Зүйл 31. ОХУ-ын зарим хууль тогтоомжийн бичиг баримт (хууль тогтоомжийн бичиг		Бүлэг 7 Устгах, хасах

	баримтын заалт)-ыг хүчингүй болсонд тооцох тухай		
15 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох	Зүйл 32. Холбооны улсын энэ хуулийг хүчин төгөлдөр болгох горим	Бүлэг IX Нэмэлт	Нэмэлт

### Үнэлгээ:

Агаар сансраас зураг авах, геодези, зураг зүйн үйл ажиллагаанд сансрын технологи, хиймэл дагуулын станц ашиглах, дроны нислэг, ортофото зураг үйлдэх, агаар сансрын зургийн боловсруулалт, тоон мэдээлэл гарган авах харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай.

Мөн томоохон хот, суурин, аймаг, сумын төв, уурхай дэд бүтцийн ажил хийгдэж байгаа газруудад тодорхой интервалтайгаар ортофото зураг авч эдийн засгийн эргэлтэд оруулах, цаашлаад түүхэн баримт болгон үлдээх нийгмийн зайлшгүй шаардлагатай.

Түүнчлэн GNSS нь орчин үед геодезийн сүлжээ байгуулах үндсэн технологи болсон тул байрлалын сүлжээг GNSS-ын технологи ашиглан байгуулах, БАСС буюу идэвхтэй сүлжээ байгуулах талаар хуулийн холбогдох хэсэг бүрт шинэ зүйл заалт нэмэх, байрлалын сүлжээ байгуулах, GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станц байгуулж ажиллуулах талаарх зохицуулалтыг хуульд шинээр тусгах шаардлагатай.

Мөн норм, нормативын баримт бичгийг боловсруулах, шинэчлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх субъектыг тодорхойлж оруулах, холбогдох санхүүжилтийг бүрдүүлэх нормчлолын санг бий болгох, сангийн эх үүсвэр, зарцуулалтыг зохицуулсан зохицуулалтыг хуульд шинээр оруулах шаардлагатай.

### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хуулийн хэрэгжилтийн байдал, үр дүнд үнэлнгээ хийхэд геодези, зураг зүйн үйл ажиллагаатай холбоотой дараах тулгамдсан асуудал үүссэн байна. Үүнд:

- Геодези, зураг зүйн үйл ажиллагааны нэр, төрөл, тоо нэмэгдсэн, шинэ нэр томъёо бий болсон боловч хуульд геодези, зураг зүйн үйл ажиллагааг бүрэн тодорхойлоогүй;
- Олон улсын жишигт нийцээгүй;
- Геодези, зураг зүйн үйл ажиллагааны захиалагч, хэрэглэгч төрийн байгууллагуудын чиг үүрэг гүйцэд тодорхойлогдоогүйгээс салбар бүрт хийж байгаа геодези, зураг зүйн ажлын үр дүн геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн санд төвлөрдөггүй;
- 1:100000-аас том масштабтай байр зүйн зургууд төрийн нууцад хамаардгаас эдгээр зургийг энгийн хэрэглээнд ашиглахад хүндрэлтэй байдаг;
- геодези, зураг зүйн үйл ажиллагааны хяналт /магадлал, магадлан хэмжилт, захиалагчийн техникийн хяналт/ хийх зохицуулалт тодорхойлогдоогүй;
- “геодезийн хэмжилт, зураглалын”, “зураг зүйн” гэсэн хоёр өөр төрлийн үйл ажиллагаанд нэг ижил шалгуур тавьж “геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх” гэсэн нэг тусгай зөвшөөрөл олгож байгаа нь практикт нийцээгүй;
- Байрлалын сүлжээ байгуулах, GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станц байгуулж ажиллуулах талаар зохицуулалтгүй;

- Геодези, зураг зүйн үйл ажиллагааг зохицуулах норм, нормативын баримт бичгийн тогтолцоо тодохойгүй, хуулиар зохицуулагдаагүй;
- Газрын харилцаа, байгаль орчин, геологи, уул уурхайн салбар болон нийслэл хотод 1990-ээд оноос хэрэгжүүлсэн улсын болон орон нутгийн төсөв, гадаад, дотоод төсөл хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэсэн газрын зураг, тоон мэдээлэлд тулгуурлан газар зүйн мэдээллийн системийг байгуулан ашиглаж эхэлсэн боловч үүсгэсэн мэдээллийн сангууд нь геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд холбогдоогүй, мэдээлэл солилцох нөхцөл бүрдүүлээгүй, нэгдсэн стандартгүйгээс мэдээллүүдийг давхцуулан ашиглах боломжгүй, ижил төрлийн ажил давхардан хийгдсэн;
- Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд газар зүйн нэрийн чиглэлээр хийх ажлыг тодорхой тусгаагүй, геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцах чиг үүрэг тодорхойгүй;
- Геодези, зураг зүйн тухай хуульд уламжлалт геодезийн сүлжээ болох байрлалын, өндрийн, гравиметрийн сүлжээний талаар тусгайлан сүлжээ гэж тусгаагүй харин геодезийн сүлжээ гэсэн нэг ерөнхий нэрийн доор нэгтгэн оруулж ерөнхийд нь зохицуулсан;
- GNSS-ийн байнгын ажиллагаатай станц, байнгын цэг тэмдэгт түүний хамгаалалтын бүс, мэдээллийн санд төвлөрүүлэх зохицуулалт байхгүй;
- Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг байгуулах, сэргээх, тоолох, бүртгэх, хадгалах, хамгаалах, шалгах талаарх зохицуулалт байхгүй;
- Агаар сансраас зураг авах харилцаа бүхэлдээ хуулиар зохицуулагдаагүй,
- дроны нислэг, ортофото зураг үйлдэх, агаар сансрын зургийн боловсруулалт, тоон мэдээлэл гарган авах харилцаа зохицуулагдаагүй;
- геодезийн хэмжилийн багаж хэрэгслийг засварлах, тохируулах, шалгах, баталгаажуулах үйл ажиллагаа, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг хуулиар тодорхой зохицуулаагүй;

Иймд геодези, зураг зүйн үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай байна. Үүнд:

1.Хуульд “Улсын солбицлын тогтолцоо”, “Солбицлын дэд тогтолцоо”, “Гравиметрийн сүлжээ”, “Өндрийн сүлжээ” гэсэн нэр томъёо, үйл ажиллагааг тодорхойлох, энэ төрлийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, санхүүжүүлэх асуулыг зохицуулах;

2.Байрлалын сүлжээ байгуулах, GNSS-ын байнгын ажиллагаатай суурин станц байгуулж ажиллуулах асуудлыг хуулиар зохицуулах;

3.Агаар, сансраас зураг авах, ашиглах, боловсруулалт хийх зэрэг харилцааг хуулиар зохицуулах;

4.Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг байгуулах, сэргээх, тоолох, бүртгэх, хадгалах, хамгаалах, шалгах асуудлыг хуульд тусгах;

5.Геодезийн хэмжилийн багаж хэрэгслийг засварлах, тохируулах, шалгах, баталгаажуулах үйл ажиллагаа, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг хуулиар зохицуулах;

6.Хуульд газар зүйн нэрийн чиглэлээр хийх ажлыг тодорхой тусгаж, геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцах чиг үүрэг тодорхой болгох, газар зүйн нэртэй холбоотой нэр томъёог холбогдох хууль тогтоомжуудад жигдлэх;

7.Геодези, зураг зүйн үйл ажиллагааг зохицуулах норм, нормативын баримт бичгийн тогтолцоог хуулиар зохицуулах;

8.Бүх салбарт хийж байгаа геодези, зураг зүйн ажлын үр дүн геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн санд төвлөрдөг байх асуудлыг хуулиар зохицуулж, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг тодорхой болгох.

Эдгээр зохицуулалтыг хуульд шинээр тусгахад Геодези, зураг зүйн тухай хуульд 50 хувиас илүү хэмжээний өөрчлөлт, шинэчлэлт орох ба Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн 25.1.1-25.1.4-д заасан нөхцөл бий болох тул Геодези, зураг зүйн тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй байна.

---oOo---